



Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
Хүүхдийн Хөдөлмөрийг Устгах Олон Улсын Хөтөлбөр

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ТУРШСАН ЗАГВАР, САЙН ТУРШЛАГЫН ТАЙЛАН





Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
Хүүхдийн Хөдөлмөрийг Устгах Олон Улсын Хөтөлбөр

“Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдтэй тэмцэх үндэсний
хугацаат хөтөлбөрийг дэмжих төсөл”
MON/05/P50/USA

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ТУРШСАН ЗАГВАР, САЙН ТУРШЛАГЫН ТАЙЛАН

2010 он
Улаанбаатар хот

Энэхүү тайланг MON/05/P50/USA төслийн хүрээнд
АНУ-ын Хөдөлмөрийн Департаментын санхүүгийн дэмжлэгтэйгээр хэвлэв.

АГУУЛГА

Товчилсон үгс	4
Удиртгал	5
Бүлэг 1: Орон нутгийн хэмжээний нэгдмэл үйл ажиллагааны сайн туршлага	8
Бүлэг 2: Ойлголт нэмэгдүүлэх үйл ажиллагааны сайн туршлага	14
Бүлэг 3: Нийгмийн түншлэл, хамтын ажиллагааны сайн туршлага	19
Бүлэг 4: Хүүхдийг хөдөлмөрөөс хөндийрүүлэх, урьдчилан сэргийлэх, тэднийг нөхөн сэргээх шууд үйл ажиллагааны сайн туршлага	22
Бүлэг 5: Хүүхдийн хөдөлмөрийн мониторингийн үйл ажиллагааны сайн туршлага	29
Хавсралтууд	
Хавсралт 1. ХХТХ-үүдийг устгахад чиглэсэн орон нутгийн хэмжээний үйл ажиллагааны загвар (2006 онд боловсруулсан хувилбар)	31
Хавсралт 2. ХХТХ-дийг устгах орон нутгийн нэгдмэл үйл ажиллагааны загварын давуу тал	34
Хавсралт 3. Хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг шийдвэрлэхэд орон нутгийн бодлого зохицуулалт, чадавхийг дээшлүүлсэн нь	36
Хавсралт 4. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүүхдийн эрхийг хангах, хянах тухай Харилцан ойлголцлын санамж бичиг	39
Хавсралт 5. Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн хохирогч хүүхдэд нийгэм, эрх зүйн үйлчилгээг хамтарсан багаар хүргэх	41
Хавсралт 6. Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн охидод сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх	44
Хавсралт 7. Тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрөөс хөндийрсэн хүүхдийн сурах боломжийг хангах	47
Хавсралт 8. Боловсролын хувилбарт хөтөлбөрийг таниулсан туршлага	49
Хавсралт 9. Урлаг, бүтээлч үйл ажиллагаагаар дамжуулан хүүхдийг нийгэмшүүлэх, хөгжүүлэх нь	51
Хавсралт 10. Алтны албан бус уурхайд хүүхдийн хөдөлмөрийг устгахад сайн дурын идэвхтнүүдийн оролцоог дайчлах нь	54
Хавсралт 11. Хүүхдийн хөдөлмөрийн талаар худалдааны захын олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх нь	57
Хавсралт 12. Хүүхдийн хөдөлмөрийн мониторинг	60

ТОВЧИЛСОН ҮГС

АБСТ	Албан бус сургалтын төв
АЙПЕК	Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөр
АНУ ХД	АНУ-ын Хөдөлмөрийн Департамент
АОЭХ	Ажил олгогч эздийн холбоо
БСШУЯ	Боловсрол,соёл, шинжлэх ухааны яам
ГБХТ	Гэр бүлийн хөгжлийн төв
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗХЖТ	Зохистой хөгжлийн жендер төв
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
НХХ	Нийгмийн хөгжлийн хэлтэс
НҮБХС	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан
НХХЯ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
ОННҮАЗ	Орон нутгийн нэгдмэл үйл ажиллагааны загвар
ОУХБ	Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
ӨҮХТ	Өсвөр үеийнхний хөгжлийн төв
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮЭХ	Үйлдвэрчний эвлэлийн холбоо
ХХМ	Хүүхдийн хөдөлмөрийн мониторинг
ХХҮХ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс
ХТХ	Хүүхдийн төлөө хэлтэс
ТББ	Төрийн бус байгууллага
ХХТХ	Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд

УДИРТГАЛ

Сайн туршлагыг тодорхойлж, түгээх нь хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх үйл ажиллагааг улам боловсронгуй болгох, үр дүнг нь сайжруулахад чухал хувь нэмэр оруулна. Сайн туршлага нь төслийн бүх үйл ажиллагааг хамарсан байх шаардлагагүй, бүхэлдээ тийм ч амжилттай бус байсан төсөлд ч гэсэн зарим үйл ажиллагаа нь амжилттай сайн хэрэгжиж бусдад түгээхүйц сайн туршлага болсон байдаг. Сайн туршлага нь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдтэй (ХХТХ) үр дүнтэй тэмцэх мэдлэгийн цар хүрээг баяжуулах, шинэлэг, бүтээлч санаачилгыг өрнүүлэх, арга туршлагаа солилцох явдлыг дэмждэг.

Энэхүү тайланд ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөрийн (цаашид АЙПЕК гэх) Монгол улсад 2005 оны 10 дугаар сараас 2010 оны 5 дугаар сар дуустал хэрэгжүүлсэн “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдтэй тэмцэх дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих хугацаат арга хэмжээний төсөл”-ийн хүрээнд бий болсон сайн туршлагуудыг тодорхойлж, баримтжууллаа.

Тайлан дараахь гурван асуудалд анхаарал хандуулав. Үүнд:

1) Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах орон нутгийн түвшний үйл ажиллагааг залуурдах, зангидахад чиглэгдсэн “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах орон нутгийн хэмжээний нэгдмэл үйл ажиллагааны загвар”-ыг нийслэл болон сонгосон аймгуудад хэрхэн ашиглаж, хэрэгжүүлсэн байдал, уг загварын давуу тал, сургамжийг баримтжуулж, улмаар загварыг цаашид бусад орон нутагт түгээн дэлгэрүүлэх санаачилгыг дэмжих;

2) АЙПЕК хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр төрийн болон төрийн бус байгууллагууд, хэвлэл мэдээллийн байгууллагуудын хэрэгжүүлсэн үйл ажиллагааны сайн туршлагуудыг танилцуулах;

3) Зарим сайн туршлагыг хэрэгжүүлсэн үйл явц, үр дүн, сургамжийг илүү дэлгэрэнгүй баримтжуулан түгээх зэрэг болно.

Тайланг бэлтгэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан үндэсний зөвлөх Бирваагийн Мөнхжаргал болон АЙПЕК-ийн хэрэгжүүлэгч байгууллагуудад гүн талархал илэрхийлье. Сайн туршлагын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг АЙПЕК-ийн төсөл хэрэгжүүлсэн байгууллагууд өөрсдөө бэлтгэсэн болно.

Сайн туршлагыг баримтжуулсан үйл явц, аргачлал. Сайн туршлагыг тодорхойлох, баримтжуулах ажлыг дараахь шат дараалсан үйл явцын дагуу хийв. Үүнд:

- АЙПЕК-ийн зүгээс боловсруулсан шалгуур, удирдамжийн¹ дагуу төсөл хэрэгжүүлэгч байгууллагууд өөрсдийн сайн туршлагаа 2009 оны 12 дугаар сард оролцооны аргаар тодорхойлж, баримтжуулав.
- Эдгээр сайн туршлагыг АЙПЕК хөтөлбөрийн зүгээс 2010 оны 1 дүгээр сарын 12-14-нд зохион байгуулсан хэрэгжүүлэгч байгууллагуудын туршлага хуваалцах семинар дээр танилцуулж, төсөл хэрэгжүүлэгч байгууллагууд харилцан туршлага солилцохын зэрэгцээ сайн туршлагын баримтжуулалтыг цаашид хэрхэн сайжруулах талаар хэлэлцэв. Энэ семинарт үндэсний зөвлөх ажиглагчийн үүрэгтэй оролцож, байгууллагуудын сайн туршлагуудтай танилцсан юм.
- Үндэсний зөвлөх АЙПЕК-ийн төсөл хэрэгжсэн орон нутгуудад очиж бодит байдалтай танилцан, төсөл хэрэгжүүлсэн баг, төсөлд хамрагдсан хүүхдүүд болон

¹ ОУХБ-ын АЙПЕК-ийн Удирдах газраас боловсруулсан удирдамж, 2003 он

эцэг эх, нутгийн иргэдийн төлөөлөгчидтэй уулзаж ярилцан, сайн туршлагын талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авч, сайн туршлагыг баталгаажуулан баримтжууллаа. Төсөл хэрэгжүүлсэн байгууллагууд зөвлөхтэй нээлттэй мэдээлэл солилцсоны үндсэн дээр шинээр сайн туршлага нэмж тодруулах, эсхүл урьдчилан тодорхойлсон сайн туршлага нь тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу нягталж үзэхэд сайн туршлага биш болох тохиолдол гарч байв.


ОУХБ-ын АЙПЕК хөтөлбөрөөс боловсруулсан дараахь долоон шалгуур үзүүлэлтийг ашиглан байгууллагуудын сайн туршлагыг тодорхойлсон болно. Үүнд:

- шинэлэг бүтээлч байх
- үр өгөөжтэй байх
- түгээн дэлгэрэх боломжтой байх
- тогтвортой үргэлжлэх боломжтой байх
- нийц, хамааралтай байх
- хариуцлага ёс зүйд нийцсэн байх
- үр ашигтай, хэрэгжих боломжтой байх гэх мэт болно.

Хүүхдийн хөдөлмөрийг устгах нь холбогдох мэргэжлийн бүлэг, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, бодлого, стратегийг төлөвлөх, хүний нөөцийг чадавхижуулах, хүүхдийг хөдөлмөрөөс хөндийрүүлэх, тэдэнд нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, мониторинг, үнэлгээ хийх зэрэг бие биенээсээ хамааралтай үе шатууд бүхий цогц үйл ажиллагаа юм. Тиймээс сайн туршлагуудыг эдгээр үйл ажиллагааны чиглэлээр танилцуулж байна. Үүнд:

- Нийслэлийн ЗДТГ, Налайх дүүрэг, аймгуудад туршсан хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах орон нутгийн хэмжээний нэгдмэл үйл ажиллагааны сайн туршлага
- Ойлголт нэмэгдүүлэх, ухуулга сурталчилгааны сайн туршлага
- Нийгмийн түншлэл, хамтын ажиллагааны сайн туршлага
- Хүүхдийг хөдөлмөрөөс хөндийрүүлэх, урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх үйл ажиллагааны сайн туршлага
- Хүүхдийн хөдөлмөрийн мониторингийн сайн туршлага

Зураг 1. Сайн туршлагыг үйл ажиллагааны чиглэлээр ангилсан нь



Сайн туршлага бий болсон нөхцлүүд. АЙПЕК хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн төсөл, үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх бүх үйл явцыг **багаар ажиллах, санал солилцох, зөвлөлдөх, оролцуулах зарчмыг** дэмжин хэрэгжүүлж байсан нь сайн туршлага гарах үндсэн нөхцөл болсон гэж дүгнэж байна. Энэ зарчмыг дэмжсэнээр төсөл хэрэгжүүлэгч байгууллагууд асуудлыг тодорхойлох, түүнийг шийдвэрлэхэд идэвхтэй, бодитой, өөриймсгөөр хандах боломжийг олгосон юм.


БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ХЭМЖЭЭНИЙ НЭГДМЭЛ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЙН ТУРШЛАГА

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгахад чиглэсэн тогтвортой үйл ажиллагааг орон нутгийн түвшинд төлөвшүүлэх зорилгоор “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах орон нутгийн хэмжээний нэгдмэл үйл ажиллагааны загвар”-ын (цаашид ОННҮАЗ гэх) төслийг АЙПЕК хөтөлбөр, Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яам, Монголын Ажил Олгогч Эздийн Холбоо болон Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбооны холбогдох техникийн ажилтнууд хамтран боловсруулж, улмаар Хүүхдийн хөдөлмөрийн асуудлаарх Үндэсний зохицуулах хороогоор хэлэлцүүлж, дэмжүүлсэн юм. Улмаар уг загварын төслийг Улаанбаатар хот болон сонгосон орон нутаг буюу Өвөрхангай, Баянхонгор, Төв, Дорноговь, Дорнод аймаг бүрт зохион байгуулсан зөвлөлдөх уулзалтаар хэлэлцүүлж, төсөл хэрэгжүүлэгчдийн дэмжлэгийг авсан юм.



ОННҮАЗ нь долоон бүрэлдэхүүн хэсэгтэй, (тодорхойлогдсон бүрэлдэхүүн хэсэг бүрт хамааралтай долоон үндсэн зарчимтай) бүрэлдэхүүн хэсэг бүрт тодорхой стратегиуд тусгагдсан болно. Загварын бүтцийг Зураг 2-т үзүүлэв. (Загварын төслийг Хавсралт 1-ээс харна уу).

Зураг 2. ОННҮАЗ-ын бүрэлдэхүүн хэсгүүд



ОННҮАЗ-ыг хэрэгжүүлэх хүчин чармайлт төсөл хэрэгжүүлсэн орон нутгуудад нэлээд далайцтай өрнөсний нэг чухал хүчин зүйл нь нийслэл, таван аймаг бүр ХХТХ-дийг устгах орон нутгийн дэд хөтөлбөрийг боловсруулж, орон нутгийн ИТХ-аар батлуулан, дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах ажлын хэсгийг аймаг, нийслэлийн Засаг даргын орлогч, эсвэл Нийгмийн бодлогын хэлтсийн даргаар ахлуулан байгуулсан явдал юм. Ийнхүү эдгээр орон нутагт хэрэгжүүлсэн АЙПЕК-ийн үйл ажиллагааны хөтөлбөрөөр дамжуулан уг загварыг нийслэл хот, таван аймагт туршлаа. Орон нутгийн дэд хөтөлбөр, загварын хэрэгжилтийг дэмжих зорилгоор АЙПЕК хөтөлбөрийн нэгжээс техникийн зөвлөгөө, санхүүгийн дэмжлэг үзүүлсэн ба техникийн дэмжлэг нь загварын долоон бүрэлдэхүүн хэсгийг жигд хэрэгжүүлэх орон нутгийн чадавхийг хөгжүүлэхэд чиглэж байлаа.

ОННҮАЗ нь холбогдох бүх байгууллага хамтран үйл ажиллагаагаа уялдуулан хүүхдийн хөдөлмөртэй иж бүрэн тэмцсэнээр бодит үр дүнд хүрснийг практик амьдрал дээр харуулсан шинэлэг, бүтээлч арга хэрэгсэл болсон бөгөөд Монгол Улсад хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх үйл ажиллагааг шинэ түвшинд ахиулсан алхам болсон гэж үзэж байна. Ялангуяа загварыг Нийслэлийн дүүргүүд дотроос илүү цогцоор хэрэгжүүлсэн Налайх дүүрэг, Баянхонгор, Өвөрхангай, Дорнод аймгийн туршлага үүнийг баталж байна.

Хүүхдийн хөдөлмөрийн асуудалд цогцоор хандах, холбогдох салбар, байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдааг хангах, тухайн орон нутаг, байгууллага асуудалд өөриймсгөөр хандан, харилцан зөвшилцсөний үндсэн дээр төлөвлөх, шийдвэрлэх, хамтран хэрэгжүүлэх тасралтгүй үйл явцыг дэмжиж байгаа нь ОННҮАЗ-ын давуу тал юм (Загварын давуу тал, үр дүнгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 2-оос үзнэ үү).

Зураг 3. ОННҮАЗ-ын давуу тал



Бодлого, хөтөлбөрийн уялдаа, салбар хоорондын оролцоог хангасан бүтэц, зохион байгуулалтыг бүрдүүлэх, орон нутгийн бодлогод хүүхдийн хөдөлмөрийг устгах зорилт, үйл ажиллагааг тусгах, ойлголт дээшлүүлэх, сургалт сурталчилгааг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхэлдэг болон эрсдэлтэй хүүхдүүдэд хүрч ажиллан үйлчилгээ үзүүлэх, олон нийтийг дайчлах зэрэг олон арга хэмжээг цогцоор төлөвлөсөн нь загварыг туршсан орон нутгуудад жигд амжилттай хэрэгжив.

Орон нутгийн хэмжээнд хүүхдийн хөдөлмөрийг устгах зорилтыг Засаг даргын мөрийн хөтөлбөр, нийгэм эдийн засгийн үндсэн чиглэлд тусгаснаас гадна “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд хүүхдийн хөдөлмөрийг устгахтай холбоотой үүрэг хариуцлагыг бүх салбарын байгууллага, ажилтны чиг үүрэг, ажлын байрны тодорхойлолт, ажлын үр дүнгийн гэрээнд тусгаснаар хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг ганц байгууллага бус холбогдох бүх байгууллага хамтран хариуцаж, санхүү, хүний нөөцийн боломжийг харилцан уялдаатай, үр ашигтай зарцуулах замаар тодорхой үр дүнд хүрэх нөхцлийг бүрдүүлэх эхлэл тавигдсан байна. Түүнчлэн багаар ажилласнаар хүүхдийн асуудлыг олон өнцгөөс нээлттэй харах, бүтээлчээр хандах, шийдлүүдийг зөвшилцөх, хамтран хэлэлцэх явдал тогтмолжиж байгаагаас гадна бие биенээсээ суралцах, чадавхижих боломжийг олгож байна.

Загвар нь бодлогын уялдаа, салбар хоорондын хамтын ажиллагаанд тулгуурлан хэрэгжсэн нь бүтээлч, үр ашигтай санал санаачилгууд гарах нөхцөл болжээ. Тухайлбал, Өвөрхангай аймагт хэрэгжүүлсэн сайн малчныг шалгаруулах журамд хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг тусган шинэчилсэн, Налайх дүүрэг, Дорнод, Өвөрхангай аймагт хэрэгжүүлсэн хүүхдийн хөдөлмөрийн мониторингийн багийн үйл ажиллагааны туршлага, Баянхонгор аймагт хэрэгжсэн албан бус алт олборлогчдыг хүүхдийн хөдөлмөрийн эсрэг нэгтгэсэн сайн туршлага зэрэг нь орон нутгийн нэгдмэл үйл ажиллагааны загварын хүрээнд бий болжээ.

Хүүхдийн түүх. Миний ирээдүй гэрэл гэгээтэй болсон

Намайг Н. гэдэг. Дөрөвдүгээр ангид ордог жил ээж маань гэнэт нас барсан тул би холын хамаатныдаа очсон. Аав маань намайг бүр багад өөд болсон гэсэн. Амьдарч байгаа ахынх маань ам бүл 6-уул. Ах, эгч хоёр маань боловсрол мэргэжилгүй, ажил төрөлгүй болохоор надтай нийлээд 5 хүүхэд тэжээх гэдэг хэцүү байсан. Тэгээд ажил хийж эгчид туслах нэрээр хичээлээ тасалдаг байсан боловч дараа нь ахыг даган нүүрс савлаж, хүмүүсийн авсан нүүрсийг үүрч унаан дээр нь хүргэж өгдөг болсон. Ингэсээр байгаад сургуулиас завсардаж, мөнгө олох ямар л ажил байна түүнийг хийдэг болсон. Хуванцар сав, шил түүдэг, түлээ нүүрс савладаг, үүрдэг, дараа жилээс нь Уянга сумын Өлтийн алтанд явдаг боллоо. Тэнд маш хэцүү байсан. Өдөр, шөнөгүй гараа хагартал шавартай усанд шороо зайлна. Архичин согтуу, хараасан, дээрэмдсэн, зодолдсон хүмүүсийн дунд байх ямар л олигтой байх вэ дээ...

Одоо бодоход бүх л юм харанхуй нүх шиг байжээ. Албан бус сургалтад суралцаж, төслийн дэмжлэгээр хичээлийн хэрэгсэл, үдийн цайнд хамрагдаж санаа зовох зүйлгүй хичээлдээ мэрийсэн дээ. Бүтэн өнчин хүүхдийн тэжээгчээ алдсаны тэтгэмжээ ч авч эхэлсэн. Манай ах ч гэсэн төслийн үр шимээр мэргэжлийн сургалтанд хамрагдаж, одоо барилгын компанид ажиллаж байна. Би төслийн ачаар суурь боловсрол эзэмшсэний дараа Өвөрхангай аймаг дахь ШУТИС-ийн харъяа МСҮТ-ийн барилгын өргөн мэргэжлийн ангид суралцаж байна. Миний ирээдүй, манай гэрийнхний амьдрал үнэхээр гэрэл гэгээтэй байгаа.

Загвар нь хот суурин газар болон хөдөө орон нутгийн онцлогийг харгалзан асуудлаа тодорхойлж, үйл ажиллагаагаа төлөвлөх боломжийг бүрдүүлж байна. Тухайлбал, аймгуудад мал аж ахуйн салбар, албан бус уул уурхай дахь (тухайн аймгаас хамааран)


хүүхдийн хөдөлмөрт түлхүү анхаарч байхад Улаанбаатар хотод хүүхдүүд зах дээр хүнд ачаа зөөх, бэлгийн мөлжлөгт өртөх, гуйлга гуйх, бага насны хүүхдүүд гудамж, зах дээр наймаа хийх зэрэг хүүхдийн хөдөлмөрийн хэлбэрүүдтэй тэмцэх асуудалд илүүтэй анхаарал хандуулсан байна.

ОННУАЗ-ын хүрээнд холбогдох байгууллага, мэргэжилтнүүд болон нийгмийн түншүүдийн хамтын ажиллагаа сайжирч байна. Салбар дундын баг АЙПЕК-ийн төсөл хэрэгжүүлсэн орон нутаг бүрт байгуулагдаж, ХХТХ-үүдийн туршлага, мэдлэг, хамтын ажиллагаагаа чиглүүлж байна.


Салбар дундын багийн ажлын үндсэн чиг үүрэг нь ХХТХ-тэй тэмцэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөх, зохицуулах, гүйцэтгэхэд чиглэж байгаа бол багийн гишүүдийн үүрэг нь өөр өөрийн үүрэг хариуцлагын дагуу тодорхойлогдож, үр дүнгийн гэрээнд тусгагдан ажлаа тайлагнах зарчимд тулгуурлаж байна. Тухайлбал, нийгмийн хөгжлийн хэлтэс хүүхдийн нийгмийн хамгааллыг сайжруулах бодлого, үйл ажиллагааг зохицуулах, тайлагнах, багийг тогтвортой ажиллуулах үүрэг хариуцлага хүлээсэн бол мэргэжлийн хяналтын газар хуулийн дагуу үзлэг шалгалт хийх, мөрдүүлэх, зөрчил илрүүлэх чиглэлээр, эрүүл мэндийн газар эрүүл мэндийн үзлэгт хамруулах, эрүүл ахуйн сургалт явуулах, боловсрол соёлын газар албан бус болон албан сургалтад хамруулах, багш, сурагч, эцэг эхийн холбоог сайжруулах, хөдөлмөр халамж үйлчилгээний газар эцэг эх, гэр бүлийн гишүүдийг нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулах, амьдрах ур чадварын сургалтад хамруулах, ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх, үйлдвэрчний эвлэл болон ажил олгогч эздийн төлөөлөл гишүүн байгууллагууддаа сургалт зохион байгуулах, хяналт явуулах зэрэг чиглэлээр тодорхой үүрэг хариуцан ажиллаж байна.

Зураг 4. Салбар дундын багийн ерөнхий бүтэц

а) Аймаг, нийслэл хот, Налайх дүүргийн түвшинд



б) Сумын түвшинд



Салбар дундын багийн нэг сайн жишээ нь Өвөрхангай аймагт байгуулагдсан “Хүүхэд хамгааллын баг” юм. Сум бүрт хүүхдийн асуудал хариуцсан орон тооны ажилтан ажилладаг давуу талаа ашиглан хүүхэд хамгааллын багийг байгуулан тогтвортой үйл ажиллагааг нь ханган ажиллаж байна (Энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 3-аас үзнэ үү).



Гэхдээ загварын долоон бүрэлдэхүүн хэсгийн хэрэгжилт харилцан адилгүй байлаа. Тухайлбал бодлого, бүтцийн хариуцлагыг тодорхой болгох, ойлголт нэмэгдүүлэх, орон нутгийнхнийг түшиглэн хүүхдийн хөдөлмөрийн байдалд мониторинг хийх, хүүхдэд шаардлагатай үйлчилгээ үзүүлэх, нийгмийн түншлэлийг хөгжүүлэх бүрэлдэхүүн хэсгүүд илүүтэй жигд сайн хэрэгжсэн байхад хууль сахиулах, мэдээлэл

судалгааг боловсронгуй болгох бүрэлдэхүүн хэсгүүдийн хэрэгжилт харьцангуй сул байлаа. Энэ нь загварын бүх бүрэлдэхүүн хэсгийг жигд хэрэгжүүлэх боломж, чадавхи харилцан адилгүй, цаг хугацаа хангалтгүй байсан, бусад бүрэлдэхүүн хэсгүүдэд илүү анхаарал төвлөрүүлсэнтэй холбоотой байж болно. Нөгөө талаас хүүхдийн хөдөлмөр болон бэлгийн мөлжлөгийг хориглох, гэм буруутай этгээдийг шийтгэх хууль эрх зүйн орчин боловсронгуй бус, хөдөлмөрийн хяналт албан бус хэвшилд тэр бүр хүрч ажилладаггүй, түүнчлэн хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага сул, бүртгэл хяналтаас гадуурх албан бус салбарт хүүхдийн хөдөлмөр түлхүү ашиглагддаг, хүүхдийн хөдөлмөрийн мэдээллийг захиргааны албан мэдээллийн тогтолцоонд оруулах аргачлал боловсронгуй болж чадаагүйтэй холбоотой байж болох юм. Цаашид холбогдох хууль тогтоомж, бодлогыг боловсронгуй болгох чиглэлээр үндэсний түвшинд нэлээд ажил хийж, улмаар орон нутгийн чадавхийг дэмжих шаардлагатай нь харагдлаа.

ОННУАЗ-ын дагуу АЙПЕК-ийн төсөл хэрэгжүүлснээр орон нутагт гарсан үр дүн:

- Хүүхдийн хөдөлмөрийг устгах асуудал орон нутгийн үндсэн бодлого, хөтөлбөртэй уялдаж, хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх олон чиглэлийн үйл ажиллагааны уялдаа, нэгдмэл байдал сайжирсан,
- Аймаг, нийслэл, сумдын түвшинд салбар дундын баг захиргааны бүтцэд түшиглэн байгуулагдаж, тодорхой ажлын чиг, удирдамжийн дагуу ажиллах болсноор ХХТХ-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хамтын хариуцлагын тогтолцоо бүрдэж, холбогдох байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа, хүн хүч, хөрөнгийн зарцуулалтын үр ашиг сайжирсан,
- Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг гурван талт түншлэл, төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирсан,
- Хүүхдийн хөдөлмөрийн олон талт асуудлын тухай ойлголт, мэдлэг нэмэгдсэн,
- Багаараа, хамтарч асуудлыг тодорхойлж, шийдэж байгаа нь идэвхтэй оролцоо, санаачилга, бие биенээсээ суралцах үйл явцыг дэмжсэн байна.

Загвар нь хүүхдийн хөдөлмөрийг устгах асуудлыг үр дүнтэй цогц шийдвэрлэх, нэгдмэл арга хэмжээний чиглэл болж өгч чадаж байгаа тул түүнийг хэрэгжүүлсэн газрууд энэ загварыг АЙПЕК –ийн төсөл дууссаны дараа цаашид үргэлжлүүлэн ашиглах талаар тодорхой арга хэмжээ авч байна. Тухайлбал, ажлын хэсгийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх зорилгоор цаашдын үйл ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилтийн талаар санал боловсруулж шийдвэрлүүлэх, орон нутгийн дэд хөтөлбөрийг сунган хэрэгжүүлэх боломжийн талаар санал солилцож зөвшилцөх зэрэг ажил хийгдэж байна. Гэхдээ төлөвлөсөн төсвийн хэмжээ бага байгаа нь уг загварыг хэрэгжүүлэх хүрээг багасгахад нөлөөлж болзошгүй байна.

Цаашид загварын бүрэлдэхүүн хэсгүүдийн хоорондын уялдаа, харилцан үйлчлэлийг бэхжүүлэхийн тулд загварын үйл ажиллагааны хүрээг хумихгүйгээр зарим тодотгол, нэмэлт оруулах боломжтойг үндэсний зөвлөх санал болгосон юм.

Загвар нь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах үйл ажиллагааг орон нутагт төлөвлөх, хэрэгжүүлэх, орон нутгийн түвшинд асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн хамтын ажиллагаа, үр дүнтэй аргачлалыг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой арга хэрэгсэл гэдэг нь тодорхой болсон тул түүнийг бусад орон нутагт түгээх нь зүйтэй гэж үзэж байна.

БҮЛЭГ 2. ОЙЛГОЛТ НЭМЭГДҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЙН ТУРШЛАГА

Тайлангийн энэ хэсэгт дурьдсан сайн туршлагуудыг дараахь гурван чиглэлээр танилцуулж байна. Үүнд:

1. Бодлого боловсруулагчид, хэвлэл мэдээллийнхэнд нөлөөлөх, тэднийг дайчлах чиглэлийн үйл ажиллагаа
2. Олон нийтийн ойлголт, хандлагыг өөрчлөх ухуулга, сурталчилгаа
3. Мэргэжлийн бүлгүүдийн ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх сургалт, хөтөлбөр

Бодлого боловсруулагчид, хэвлэл мэдээллийн байгууллагуудад нөлөөлөх тэдний оролцоог дайчлах

ХХТХ-үүдийг устгахад чиглэсэн нөлөөллийн стратеги. Хүүхдийн хөдөлмөрийг бууруулах, нэн түрүүнд ХХТХ-ийг устгахад хууль тогтоогчид, төрийн захиргаа, үйлчилгээний байгууллага, ажил олгогчдын ба үйлдвэрчний эвлэл холбоо, иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, иргэд, хүүхдүүд, гэр бүл зэрэг нийгмийн бүхий л хүрээнд ойлголт нэмэгдүүлэх шаардлагатай. Иймд Монгол улсын нэгдэж орсон олон улсын гэрээ, Конвенцуудын үзэл санаа, үндэсний бодлого, холбогдох хууль тогтоомжид үндэслэн хүүхдийн хөдөлмөрийн талаар зөв ойлголтыг бүх түвшинд өгөх нь хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангаж, олон нийтийн дэмжлэг авахад ихээхэн ач холбогдолтой байв. Тиймээс хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар нэгдсэн ойлголт төлөвшүүлэх, нийгмийн түншлэлийн анхаарлыг төвлөрүүлж тасралтгүй хандуулах, олон нийтийн дэмжлэг, орон нутгийн үйл ажиллагааг тогтвортой үргэлжлүүлэх зорилгоор "Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн эсрэг нөлөөллийн стратеги"-ийг боловсруулж, Ерөнхий сайдаар ахлуулсан Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлөөр батлуулсан юм.

Нөлөөллийн стратеги нь ойлголт нэмэгдүүлэх үйл ажиллагааг зорилтот бүлгийн онцлог, тухайн асуудлын мөн чанарыг харгалзан хэрэгжүүлэхэд хувь нэмэр орууллаа. Олон нийт, зорилтот бүлэг, мэргэжлийн байгууллагуудад хүргэх мэдээллийг энгийн хэллэгтэйгээр, ойлгомжтой, дэлгэрэнгүй тодорхойлсон нь аль ч түвшинд ямар ч байгууллага, иргэдэд хэрэгтэй баримт бичиг болсон.

Нөлөөллийн стратегийг оролцооны аргаар боловсруулж, түүнийг түгээх, дэмжих ажлыг шат дараатай хэрэгжүүлсэн нь тэмдэглүүштэй юм. Нөлөөллийн стратегийг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Хүүхдийн төлөө үндэсний газар, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо болон Монголын хэвлэлийн хүрээлэн хамтран боловсруулсан. Улмаар нөлөөллийн стратегийг амьдралд хэрэгжүүлэх санаачилга, хүчин чармайлтыг дэмжих зорилгоор стратегийг таниулах сургалтыг хот хөдөөгийн сэтгүүлчдэд зориулан зохион байгуулах, АЙПЕК-ийн төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудын нөлөөллийн ажил хийх чадавхийг дэмжсэн гарын авлага боловсруулах, сургалт зохион байгуулах, Хэвлэлийн Хүрээлэнтэй хамтран хэвлэл мэдээллийн хэрэгслийг хүүхдийн эрх, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах зорилтод нэгтгэх зэрэг олон үйл ажиллагааг шат дараатай хэрэгжүүлсэн.

Хэвлэл мэдээллийн байгууллагуудын харилцан ойлголцлын санамж бичиг. Хүүхдийн эрх, хүүхдийн хөдөлмөрийн асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулах, ойлголт нэмэгдүүлэхэд хэвлэл мэдээллийн идэвхтэй оролцоо чухал. Монголын Хэвлэлийн хүрээлэн (МХХ) нь АЙПЕК хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хүүхдийн асуудал, ялангуяа хүүхдийн эрх, хүүхдийн хөдөлмөр, хүчирхийллийн асуудалд хэр анхаарал хандуулж байгаад судалгаа хийж үзэхэд мэдээллийн агуулгын тун бага хувийг хүүхдийн асуудалд зарцуулдаг дүн гарсан юм.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийг хүүхдийн эрхийн асуудалд хандуулах, тэдний үүрэг хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн Хэвлэлийн хүрээлэнгийн далайцтай, шинэ санаачилга бол үндэсний хэмжээний томоохон мэдээллийн хэрэгслүүдийг хүүхдийн эрхийн төлөө “Ойлголцлын санамж бичиг”-т нэгтгэсэн явдал билээ. Уг санамж бичиг нь дараахь асуудалд хэвлэл мэдээллийн байгууллагуудын анхаарлыг хандуулсан юм:

- Хүүхдийн үндсэн эрхүүд, түүний дотор эдийн засгийн болон бэлгийн мөлжлөгөөс ангид байх, хамгаалуулах эрхийг хүлээн зөвшөөрч, тэдгээрийг төр, нийгэм, эцэг эх, олон нийт, бизнесийнхэн хэрэгжүүлэхэд хяналт тавих .
- Хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн хөгжил, хамгааллын асуудлыг нийтлэл, нэвтрүүлгийн бодлогодоо тусгах, энэ зорилгоор хүүхдийн эрхийн асуудлаар дагнан мэргэшсэн редакци, сэтгүүлч, хүүхдийн асуудалд хандсан тогтмол булан, нэвтрүүлэгтэй байхыг байгууллагын бүтэц зохион байгуулалтад харгалзах.
- Хүүхдийн асуудлыг нийтэлж, нэвтрүүлэхдээ ёс зүйн болон мэргэжлийн хэм хэмжээг чанд баримтлах.
- Хүүхдэд зориулсан нийтлэл, нэвтрүүлгийг хүүхдийн сэтгэхүйн хөгжил, насны онцлогоор ангилан ялгах, сөрөг эрсдэлтэй мэдээллээс хүүхэд, өсвөр үеийнхнийг хамгаалах зорилгоор телевизийн нэвтрүүлгийн ангиллын системийг хэрэгжүүлэх.
- Хүүхдийн асуудалд онцгой анхаарал, мэдрэмжтэй хандаж, хүүхдийн аюулгүй байдал, эрүүл мэнд, ёс суртахуунд хор хөнөөлтэй мэдээлэл, сурталчилгаанаас зайлсхийж, хүүхдийн нэвтрүүлэг дундуур хүүхдэд шууд хандаагүй зар сурталчилгаа явуулахаас татгалзах.
- Хүүхдийн эрхийн асуудлыг илүү өргөн цар хүрээнд тусган ажиллахыг бусад хэвлэл мэдээллийн байгууллагад уриалах г.м. болно.

Хэвлэл мэдээллийнхэн ийнхүү хүүхдийн эрхийн асуудлаар Санамж бичигт нэгдсэн нь тус салбарын хувьд хамгийн анхны санаачилга юм. Энэ санаачлагыг орон нутгийн түвшинд дэлгэрүүлж хэрэглэх бүрэн боломжтой юм. (Ойлголцлын санамж бичгийг зөвшилцөж тохирсон үйл явцын тухай дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 4-өөс үзнэ үү)

Судалгааны дүнд үндэслэн хэвлэл мэдээллийнхний дунд хүүхдийн хөдөлмөрийн талаар нэгдсэн ойлголт өгөх, улмаар тэдний оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Хүүхэд-сэтгүүлч” клубыг АЙПЕК төслийн дэмжлэгтэйгээр байгуулсан нь хүүхдийн эрхийн асуудлаар ажилладаг бусад олон улсын байгууллагын дэмжлэгийг хүлээж, одоо энэ клуб хүүхдийн эрхийн олон талт асуудалд анхаарал хандуулсан сургалтын үйл ажиллагаагаа тасралтгүй явуулсаар байна. Мөн “Хүүхдийн хөдөлмөр” сургалтын гарын авлагыг боловсруулан хэвлүүлж, Хүрээлэнгийн дэргэдэх Сэтгүүлчийн дээд курсийн сургалтын хөтөлбөрт ашиглаж байна.

Олон нийтийн ойлголт, хандлагыг өөрчлөх ухуулга сурталчилгаа

Их дээд сургуулийн сургалтын хөтөлбөр. Их дээд, сургуулийн оюутнууд хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг сэдэвчлэн судлах, улмаар хүүхдийн хөдөлмөр, түүний тэвчишгүй хэлбэрүүдийн талаар оюутан залуучуудын эрх зүйн болон практик ойлголтыг дээшлүүлэх зорилгоор холбогдох их дээд сургуулиудын сургалтын хөтөлбөр дэх хүүхдийн хөдөлмөрийн талаарх хичээлийн сэдэв, хөтөлбөрийг боловсронгуй болгох, эсвэл шинээр сургалтын хөтөлбөрт оруулах, ОУХБ-аас гаргасан их дээд сургуулийн оюутнуудын сурах бичгийг орчуулж хэвлүүлэн сургалтад ашиглах, хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар оюутан залуусын эрдэм шинжилгээний ажлыг дэмжиж ажиллав. Зарим ажлыг нь НҮБ-ын Хүүхдийн Сантай хамтран хэрэгжүүлсэн нь хүүхдийн эрх, хүүхдийн хөдөлмөрийн асуудалд нэгдмэл байдлаар хандаж, ойлголт, тодорхойлолтын зөрүүгээс сэргийлэхэд үр нөлөөтэй байв. Хүүхдийн хөдөлмөрийн сэдвийг судлах нь оюутан сурагчдын кредит цагт тооцогдож байгаагаас гадна оюутнууд хүүхдийн хөдөлмөрийн сэдвээр курс, дипломын ажил хамгаалах нь нэмэгдэж байна.



Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг Дэлхийн Өдрийг тохиолдуулсан үндэсний хэмжээний сурталчилгаа.

Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг дэлхийн өдрийг жил бүр тодорхой сэдвийн дагуу улсын хэмжээнд тэмдэглэх ажлыг хэвшүүлэхэд Хүүхдийн төлөө үндэсний газар чухал үүрэг гүйцэтгэв. 2006 оноос Монгол Улсын Ерөнхий Сайдын албан даалгаврыг бүх аймаг, нийслэл хотын Засаг дарга нарт хүргүүлэн Хүүхдийн хөдөлмөрийн

эсрэг дэлхийн өдрийг тэмдэглэх сарын аянг өрнүүлж, олон нийтийн ойлголт нэмэгдүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулсаар ирлээ.

Тодорхой сэдвийн дор тэмдэглэдэг Дэлхийн Өдрийг тохиолдуулан олон төрлийн арга хэмжээг урт хугацаанд, зарим үед сарын аян болгон зохион байгуулж байсан нь үндэсний ба орон нутгийн түвшний бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдыг хүүхдийн хөдөлмөрийн асуудалд анхаарч ажиллахад түлхэц болохын зэрэгцээ, олон нийтийг хамруулсан шинэлэг, сонирхолтой арга хэлбэрээр хүүхэд, иргэд өөрсдийн эрх ашгийг хөндсөн, тулгамдсан асуудлаа зохих албаны хүмүүст хүргэх, илэрхийлэх бололцоог олгосон байна.



Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг урлагийнхны дуу хоолой.

Хүүхдийн хөдөлмөрийн сэдвээр уран зураг болон фото зургийн уралдаан зарлаж шалгаруулан, шилдэг бүтээлүүдээр Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей болон Уран зургийн галерейд үзэсгэлэн гаргаж, уран бүтээлчдийн төлөөлөгчдийн хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн эсрэг үзэл бодол,

санаа зовнилийг олон нийтэд хүргэж, улмаар зургийн цомог, цуврал баримтат киног сургалтын багц болгон бэлтгэж, мэргэжлийн бүлгүүд, хүүхэд, эцэг эхчүүдийн ойлголтыг дээшлүүлэх үйл ажиллагаанд ашиглаж байна.

Дүрслэл, уран сайхны аргаар хүүхдийн хөдөлмөр, түүний шалтгаан, хүүхдийн сэтгэл зүй, бие бялдарт үзүүлж буй хор уршиг, мөн хөдөлмөр эрхэлдэг хүүхдийн хүсэл эрмэлзлэлийн талаар урлаг, фото зургийн бүтээл, баримтат кинонууд харуулсан нь хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг бүх насны хүмүүст тэдний боловсролын түвшинг харгалзахгүйгээр ойлгуулахад чухал үр нөлөөтэй юм. Эдгээр цуврал арга хэмжээг хэрэгжүүлж зохион байгуулахад Угсаатны кино урлагийг дэмжигч “Цэгц” студийн залуучууд чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Засаг даргын “Илгээлт захиа”. Хүүхдээ хайрлах, аюултай хөдөлмөр ба хүчирхийллээс хамгаалах, сайн эцэг эх байхыг уриалсан илгээлт захиаг анх Налайх дүүргийн Засаг дарга дүүргийнхээ нийт 6000 өрхөд илгээсэн нь өрх гэр, иргэдэд хүүхдийн асуудлыг, тухайлбал хүүхдийг аюултай ажил эрхлүүлэхгүй байхыг ухуулсан шинэлэг хэлбэрийн сурталчилгаа болсон юм. Засаг даргын гарын үсэг бүхий илгээлт захиа нь өрхийн гишүүн бүрт хандаж, хүүхэд нүүрсний уурхай, тоосгоны үйлдвэрт ажиллахын уршигт үр дагаврын талаар мэдээлж, түүнтэй тэмцэх уриалгыг товч, энгийн хэллэгээр илэрхийлснээс гадна монгол хүний хүүхдээ хайрлан хүмүүжүүлэх арван зарчмыг дурьдсан нь уламжлалт хүмүүжил, эцэг эхийн үүрэг хариуцлагын талаарх ойлголтыг нь нэмэгдүүлжээ.

Налайх дүүргийнхэн энэ санаачилгаа АЙПЕК-ийн үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлдэг байгууллагуудын туршлага солилцох семинарын үеэр хуваалцсан нь уг санаачилгыг бусад орон нутаг өөрийн онцлогт нийцүүлэн хэрэглэхэд нөлөөлсөн юм. Тухайлбал Баянхонгор аймагт иргэддээ хандсан ийм илгээлт захиаг аймгийн Засаг дарга, Иргэдийн Хурлын Тэргүүлэгчдийн даргын гарын үсэгтэйгээр илгээсэн байна. Илгээлт захиа нь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах талаар шийдвэр гаргагчид болон иргэдийн зорилго, эрмэлзлэлийг нэгтгэсэн сурталчилгааны өвөрмөц арга хэрэгсэл болжээ.



Сэдэвчилсэн сурталчилгаа.

Сэдэвчилсэн сурталчилгааны дотроос хамгийн тэмдэглүүштэй нь хурдан морь унаач хүүхдийн эрх ашиг, аюулгүй байдлын асуудлаар олон нийтийн ойлголтыг өөрчилсөн ажил юм. Хурдан морины уралдаан бол монголчуудын соёл, уламжлалын салшгүй нэг хэсэг боловч хүүхдийн эрүүл мэнд, амь насанд аюул учруулах эрсдэл дагуулдаг. АЙПЕК хөтөлбөр, Хүүхдийн төлөө Үндэсний Газар, Хүний Эрхийн

Үндэсний Комисс, хамтран энэ асуудалд олон нийтийн анхаарлыг далайцтай хандуулахад хурдан морь унаач хүүхдийн анхны чуулган шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн юм. Эмзэг асуудлыг хөндөхөд хүүхдийн оролцоо ямар үр нөлөө үзүүлж чадахыг энэ туршлага нотолсон. Түүнчлэн үндэсний уламжлалтай салшгүй холбоотой асуудлын талаарх олон нийтийн хандлагыг өөрчлөхөд холбогдох төр, төрийн бус байгууллагууд нэгдсэн ойлголтод хүрсэн явдал их чухал байлаа. Хурдан морины хүүхдийн эрх ашиг, аюулгүй байдлыг хангахад хамтран ажиллах тухай Ойлголцлын Санамж бичигт Хүний Эрхийн Үндэсний Комисс, Хүүхдийн төлөө Үндэсний Газар, Биеийн Тамир Спортын Улсын Хороо, Монголын

Үндэсний Олимпийн Хороо, Үндэсний Их Баяр Наадмын Хурдан Морины Уралдааныг Зохион Байгуулах Хороо, Монголын Морин Спорт, Уяачдын холбоо, Монголын Үндэсний Морин Уралдааны Холбоо зэрэг томоохон байгууллагууд гарын үсэг зурцгаасан билээ. Үүний дараа хурдан морины хүүхдийн асуудлыг олон нийтийн анхаарлын төвд байлгахад чиглэсэн шат дараалсан ойлголт сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Тухайлбал, хурдан морь унаач хүүхдийн гэмтлийн талаар судалгаа хийх, уяачид, тэдгээрийн холбоодын төлөөлөгчдийн хэлэлцүүлгийг зохион байгуулах, хурдан морины уралдааны дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, олон нийтийн сурталчилгааг хэвлэл мэдээллээр болон наадмын талбай дээр зохион байгуулах, унаач хүүхдийн эрүүл мэндийн судалгааг хийх, унаач хүүхдийн гэмтэл, бэртэлтэй холбоотой мэдээллийг боловсронгуй болгох зэргээр асуудалд цогцоор хандсанаар орон нутгийн засаг захиргаа, морины уралдааныг зохион байгуулагчид, уяачид, эцэг эх, хурдан морь унаач хүүхдийн ойлголт хандлагад нэлээд ахиц гарлаа.

БҮЛЭГ 3: НИЙГМИЙН ТҮНШЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САЙН ТУРШЛАГА

Гурван талт түншлэл буюу засгийн газар, үйлдвэрчний эвлэл, ажил олгогч эздийн холбооны хамтын ажиллагаа болон нийгэм, хүүхдийн асуудлаар ажилладаг төрийн бус байгууллагууд нь хүүхдийн хөдөлмөрийг бууруулах, устгахад чухал нөлөөтэй. Ажил олгогч, үйлдвэрчний эвлэлийн байгууллагууд ажлын байр, цалин хөлсийг нэмэгдүүлэх, ажлын нөхцлийг сайжруулах асуудлыг үндэсний хэмжээнд шийдвэрлэхэд нөлөөлөхийн зэрэгцээ хүүхдийн хөдөлмөрийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, тодорхой зорилготой компанит ажил өрнүүлэх, эрх зүйн болон бусад туслалцаа үзүүлэх боломжтой байдаг. ТББ-ууд хөдөлмөр эрхэлдэг хүүхэд, эцэг эх, иргэдэд шууд хүрч ажиллан шаардлагатай үйлчилгээ үзүүлэх, тэдний эрэлт хэрэгцээг засгийн газарт ойлгуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг нийгмийн түншлэл. АЙПЕК хөтөлбөрийн хүрээнд нийгмийн түншлэл, хамтын ажиллагаа идэвхжив. Энэ чиглэлээр гарсан сайн туршлагын дийлэнх нь ОННҮАЗ-ын хүрээнд бий болжээ. Хүүхдийн хөдөлмөрийг устгах зорилт орон нутгийн нийгмийн түншлэлийн гурван талт хэлэлцээрт тусгагддаг боллоо. Тухайлбал Дорнод, Дорноговь, Баянхонгор, Өвөрхангай аймаг болон нийслэл хот, Налайх дүүрэгт хоёр жил тутам шинэчлэн байгуулдаг нийгмийн түншлэлийн гурван талт хэлэлцээрт хүүхдийн хөдөлмөрийг устгах зорилтыг хэрэгжүүлэхийн төлөө хамтран ажиллах асуудал тусгагджээ. Баянхонгор аймагт нийгмийн түншлэл хүүхдийн хөдөлмөрийн асуудлаас хальж илүү өргөн хүрээнд хөгжиж байгаа нь АЙПЕК төслийн үр нөлөө байлаа.



Баянхонгор, Дорноговь, Дорнод аймгуудын туршлага нь гурван талт хамтын ажиллагаагаар хүүхдийн хөдөлмөрийг устгахад чухал үр нөлөө үзүүлж чадахыг харуулж байна. Тухайлбал үйлдвэрчний эвлэлийн холбоо нь хүүхдийн хөдөлмөрийн талаар сургалт зохион байгуулах, өөрсдийн гишүүдээр дамжуулан хүүхдийн хөдөлмөрийн эсрэг олон нийтийн ойлголт нэмэгдүүлэх, хүүхдийн хөдөлмөрт хяналт тавих ажлыг хэрэгжүүлж байгаа бол

ажил олгогч эздийн холбоо нь аж ахуйн нэгжүүдэд хүүхдийн мөлжлөгийн хөдөлмөрийн талаар ойлголт өгөх, хүүхдийг хөдөлмөрөөс хөндийрүүлэхэд төрийн байгууллагатай хамтарч ажиллах, дэмжих, хүүхдийг тэвчишгүй хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлж байв. Баянхонгор аймгийн Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо нь сумдад хүүхдийн хөдөлмөрийн талаар сургалтууд зохион байгуулах, мөнгөн усны хор хохирлын талаар олон нийтэд мэдээлэл хүргэх, жил бүр зохиогддог Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг дэлхийн өдрийг тэмдэглэхэд байнга идэвхтэй оролцдогоос гадна өөрсдийн идэвхтэн гишүүдээр дамжуулан хүүхдийн хөдөлмөрт хяналт тавихад санаачилгатай ажиллав.

Баянхонгор аймгийн Ажил Олгогч Эздийн Холбоо: Хүүхдийн хөдөлмөрийг устгахад нийгмийн идэвхтэй хүчин болох нь

Баянхонгор аймгийн АОЭХ нь 40 гаруй гишүүнтэй, сум бүрд нэг гишүүн төлөөлөл, гурван суманд салбар холбоо бүхий байгууллага юм. Холбооны гүйцэтгэх захирал нь аймгийн ХХТХ-тэй тэмцэх дэд хөтөлбөрийн ажлын багийн гишүүн бөгөөд үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, хяналт зэрэг бүх үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог. Тэрээр аймгийн төвийн худалдааны захыг эзэмшдэг тул зах дээрээ хүүхдийн хөдөлмөрийг устгахад чиглэсэн багц үйл ажиллагааг багийн гишүүдтэй хамтран хэрэгжүүлж байна. Зах дээр хөдөлмөр эрхэлж байсан хүүхдүүдийг боловсрол нөхөн олгох сургалтад хамруулах ажлыг дэмжиж, сургалтын байр, сурагчийн ширээ, сандал зэргийг бэлтгэж, сургалтыг хоёр ээлжээр явуулах нөхцлийг хангаж өгчээ. Сургалтыг аймгийн албан бус сургалтын Гэгээрэл төвөөс зохион байгуулдаг.

Ажил олгогч эздийн холбоо нь хүүхдэд боловсрол нөхөн олгох сургалтыг дэмжихийн сацуу хүүхдийн хөдөлмөрийн талаар сурталчилгааны ажлыг (мэдээллийн самбар байрлуулах, долоо хоногт хоёр удаа захын үзэлээр хүүхдийн хөдөлмөрийн талаар захын олон нийтийн ойлголт дээшлүүлэх мэдээлэл цацах, радио, ФМ-тэй хамтрах) байнга явуулах, нийт 300 орчим лангуу түрээслэгчидтэй байгуулах түрээсийн гэрээнд хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийг ашиглахгүй байх заалтыг шинээр тусгах зэрэг үйл ажиллагааны дүнд аймгийн төвийн худалдааны зах дээрх хүүхдийн хөдөлмөрийг таслан зогсоож чаджээ.

Захын түрээслэгчидтэй хийх гэрээнд хүүхдийн хүнд, тэвчишгүй хөдөлмөрийг ашиглахгүй байх заалт оруулах туршлага анх Улаанбаатар хотын худалдааны захууд дээр бий болсон билээ. Энэ туршлага АЙПЕК-ийн төсөл хэрэгжүүлсэн бусад аймагт дэлгэрсний өөр нэг жишээ нь Дорнод аймаг юм. Дорнод аймгийн Ажил Олгогч Эздийн Холбоо нь “Шүр” зах дээр хөдөлмөр эрхэлж байсан хүүхдүүдийг хөдөлмөрөөс хөндийрүүлэхэд аймгийн Хүүхдийн Төлөө Хэлтэстэй хамтран ажиллаж, сургалтын байраар хангах, сургалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлсний зэрэгцээ зах дээр лангуу түрээслэгч, аж ахуйн нэгжүүдтэй хийх гэрээнд хүүхдийн хөдөлмөрийг ашиглахгүй байх үүргийг тусгажээ. Түүнчлэн Дорнод аймгийн АОЭХ нь худалдааны зах дээрх хүүхдийн хөдөлмөрөөс гадна насанд хүрээгүй охид буудлаар биеэ үнэлэх явдлаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлыг аймгийн зочид буудлын эзэд, ажилтнуудын дунд зохион байгуулсан нь нэлээд үр дүн өгчээ.

Дорноговь аймгийн Ажил Олгогч Эздийн Холбоо нь аж ахуйн нэгж байгууллагуудад хүүхдийн хөдөлмөрийн талаар сургалт зохион байгуулах, худалдааны зах дээр байнгын мэдээлэл сурталчилгаа явуулах, төмөр замын өртөөн дээр ачаа зөөж байсан хүүхдүүдийг хөдөлмөрөөс хөндийрүүлэхэд сумынхаа Засаг захиргаатай хамтран ажиллах талаар тодорхой үр дүнд хүрч байна.

АЙПЕК-ийн төсөл хэрэгжүүлсэн орон нутагт хүүхдийн хөдөлмөрийн эсрэг гурван талт түншлэл, хамтын ажиллагаа хөгжихөд дараахь хүчин зүйл нөлөөлсөн. Үүнд:

- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгахад ажил олгогч эзэд, үйлдвэрчний байгууллагын бодлого, стратегийн баримт бичгүүд батлагдсан,
- Нийслэл, аймаг бүрт зохион байгуулсан анхны томоохон зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлэгт Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яам, Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо, Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбооны удирдах

албан тушаалтан, ажилтнууд оролцон, хүүхдийн хөдөлмөрийг устгахад нийгмийн түншүүдийн гүйцэтгэх үүрэг, засгийн газар, ажил олгогч эзэд, үйлдвэрчний байгууллагын бодлого, стратегийг чухалчлан таниулсан,

- ХХТХ-тэй тэмцэх аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар дундын багт ажил олгогч эздийн холбоо, үйлдвэрчний эвлэлийн холбооны төлөөлөл орж ажилласан зэрэг болно.

Гэхдээ гурван талт түншлэлийн цар хүрээ газар бүрт харилцан адилгүй байгаа нь орон нутгийн түвшин дэх үйлдвэрчний эвлэл, ажил олгогчдын төлөөллийн байгууллагыг цаашид хөгжүүлэх хэрэгцээг харуулж байна.



Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн эсрэг төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа. АЙПЕК хөтөлбөртэй хамтран ажилласан ТББ-ууд хоорондоо мэдээлэл, туршлага солилцох, хамтын ажиллагааны хүрээгээ өргөжүүлэх, бодлогод нөлөөлөх чадавхиа дээшлүүлэх зорилгоор “Хүүхдийн Хөдөлмөрийн Тэвчишгүй Хэлбэрүүдийн Эсрэг Үндэсний Сүлжээ”-г санаачлан байгуулсан. Сүлжээ нь гишүүн

байгууллагуудынхаа хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх, хөдөлмөр эрхэлдэг болон эрсдэлтэй хүүхдүүдийг тэвчишгүй хөдөлмөрөөс хөндийрүүлэх, хамгаалах ур чадварыг нь дээшлүүлэх зорилгоор олон төрлийн сургалтыг гишүүн байгууллагуудынхаа чадавхийн үнэлгээнд тулгуурлан илүү чадавхжсан төрийн бус байгууллагуудын туслалцаатайгаар зохион байгуулсан нь сайн туршлага болжээ. Түүнчлэн хүүхдээр гуйлга гуйлгах зэрэг хүүхдийн хөдөлмөрийн харьцангуй шинээр бий болж дэлгэрэх хандлагатай хэлбэрүүдээс хүүхдийг хөндийрүүлэх үйл ажиллагаа туршихад хамтран ажилласан нь хамтын ажиллагааг бэхжүүлэх, хүүхдэд үзүүлсэн үйлчилгээний чанарыг сайжруулахад чухал үр нөлөөтэй байлаа.

Сүлжээний зүгээс хэрэгжүүлсэн гишүүн байгууллагуудынхаа чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагаа нь ялангуяа ядуурал, шилжих хөдөлгөөн, зохистой ажлын байрны хомсдолын улмаас хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд илүүтэй төвлөрсөн, нийт хүн амын гуравны нэгээс доошгүй хувь нь амьдардаг Улаанбаатар хотод тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрт өртсөн хүүхдүүдийг илрүүлэх, тэдэнд хүрч ажиллах, хөдөлмөрөөс хөндийрүүлэхэд орон нутгийн төр, төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, үр дүнг нь сайжруулахад бодитой хувь нэмэр оруулах боломжийг нэмэгдүүлж байна.

БҮЛЭГ 4: ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРӨӨС ХӨНДИЙРҮҮЛЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, НӨХӨН СЭРГЭЭХ ШУУД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЙН ТУРШЛАГА

Зорилтот бүлэгт чиглэсэн хүүхдийг хөдөлмөрөөс хөндийрүүлэх, урьдчилан сэргийлэх, үйл ажиллагааны сайн туршлага нь тэвчишгүй хөдөлмөр эрхэлдэг, бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг илрүүлэх, нөхөн сэргээх олон төрлийн үйлчилгээ, боловсрол нөхөн олгох, амьдрах ухааны сургалт, урлаг, спорт, бүтээлч үйл ажиллагаагаар дамжуулан хүүхдийг нээх, чадваржуулах, хүүхдийн хөдөлмөрт мониторинг хийх зэрэг чиглэлүүдэд хамаарч байна.

Бэлгийн мөлжлөгт өртсөн, өртөх эрсдэлтэй охидыг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх

Ядуурал, хуулийн хэрэгжилт сул зэргээс шалтгаалан хот суурин газарт ялангуяа Улаанбаатар хотод охидыг бэлгийн мөлжлөгт ашиглах явдал буурахгүй байна. Бэлгийн мөлжлөг далд явагддаг гэмт хэрэг тул хохирогч хүүхдийг илрүүлэх асуудал төвөгтэй, бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн хохирогч хүүхдүүд эрүүл мэнд, сэтгэл санааны гүнзгий хямралд орсон, бусдад итгэх итгэлээ алдсан, байнгын айдастай байдаг тул тэднийг хүчирхийлсэн, мөлжлөгт ашигласан этгээдээс хамгаалах, сэтгэл засал, өмгөөлөл, эрүүл мэнд, нийгмийн бусад үйлчилгээг мэргэжлийн түвшинд үзүүлэх шаардлага тулгардаг.

Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийг илрүүлэх ажиллагаа. Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв нь бэлгийн мөлжлөгт өртсөн болон өртөх эрсдэлтэй охидыг илрүүлж, нөхцөл байдал, эрэлт хэрэгцээнд нь үнэлгээ өгсний үндсэн дээр тэднийг сэтгэл засал, эрүүл мэндийн нөхөн сэргээх үйлчилгээ, амьдрах ухааны сургалтад хамруулах, тэдний эцэг эх, гэр бүлийн эерэг харилцааг дэмжих, мэргэжлийн сургалтад шилжүүлэх зэрэг үйл ажиллагаа явуулдаг. Бэлгийн мөлжлөгт өртсөн охидыг илрүүлэхэд холбогдох бусад байгууллагын оролцоо, хамтын ажиллагааг хөгжүүлсэн байна. Тухайлбал, охидыг илрүүлэхдээ эрсдэлтэй үйлчилгээний газруудын (гудамжны зогсоол, зочид буудал, шөнийн цэнгээний газар гэх мэт) жагсаалт бүрдүүлэх, үүний тулд шөнийн цагаар ажилладаг таксины жолооч зэрэг иргэдээс нэмэлт мэдээлэл цуглуулах, тэдгээр газруудад тандалт хийх, үйлчилгээний газрын ажилтнуудын ойлголтыг дээшлүүлэх замаар бэлгийн мөлжлөгт өртсөн охидын талаар тэднээс мэдээлэл хүлээж авах зэргээр илрүүлэх арга хэрэгслээ өргөжүүлсэн байна. Мөн энэ зорилгоор цагдаагийн байгууллага болон мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтын хууль зөрчсөн байгууллагуудтай хариуцлага тооцох ажлыг сайжруулахад хувь нэмэр оруулжээ. Энэ нь эргээд хууль, хяналтын байгууллагуудын хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн нөхцөл байдлын талаарх ойлголтыг нь дээшлүүлсэн. Мөн хүүхдийг бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлыг үйлчилгээний газруудын дунд зохион байгуулдаг болжээ.

Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх хамтарсан багийн аргачлал. Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн хүүхдүүд бие махбодийн болон сэтгэл санааны давхар дарамтад орж, хямрахаас гадна аюулгүй байдал нь эрсдэлд орсон байдаг. Хохирогч хүүхдийг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн гэрчээр байцаахад илүүтэй анхаараад, харин тэднийг хүчирхийлэгч, зуучлагч нараас хамгаалах, аюулгүй байдлыг нь хангах, сэтгэл санааны гүйнзгий хямралаас гаргах, нөхөн сэргээхэд тэр бүр анхаарч үздэггүй тохиолдол олонтаа гардаг. Түүнчлэн хүүхдийн аюулгүй байдлыг хангаагүйгээс хүчирхийлэгч, зуучлагч, тэдгээрийн хамаатан садны дарамт, шахалтад орж, улмаар мэдүүлгээсээ буцсанаар гэмт хэрэгтнүүд хуулийн шийтгэлийн гадна үлдэж, ял завших, эсвэл зарим тохиолдолд хүүхдийг худлаа мэдүүлэг өгсөн хэргээр өөрт нь ял тохоож дахин хохироох зэргээр хүүхдийн эрхийн ноцтой зөрчлүүд

гарч байна. Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв нь бусад төрийн бус байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтран хэрэгжүүлсэн төслийн хүрээнд бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн хүүхдүүдэд хамгаалах байр, эрх зүйн өмгөөлөл, сэтгэл засал, эрүүл мэнд, нийгмийн цогц үйлчилгээг хамтарсан багаар үзүүлснээр гэмт хэргийг нотлох, гэмт хэрэгтнийг яллах үйл ажиллагааг илүү шуурхай болгох боломжийг нэмэгдүүлж, улмаар хүүхдийг харьцангуй богино хугацаанд сэтгэл санаа, эрүүл мэндийн хувьд нөхөн сэргээж, хэвийн амьдралд нь буцаан оруулах боломжтойг ойлгуулсан нь хамтарсан багийн үйл ажиллагаа ямар чухал ач холбогдолтой болохыг харууллаа (Хамтарсан багийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 5-аас үзнэ үү).

Охидын соёл, хөгжлийн төв. Дорнод аймгийн ЗДТГ-ын харьяа Хүүхдийн Төлөө Хэлтсийн дэргэд АЙПЕК хөтөлбөрийн дэмжлэгтэй байгуулсан энэ төв нь хөдөлмөр эрхэлж байсан (үүнд бэлгийн мөлжлөгт өртөж байсан охид багтана) болон хөдөлмөр эрхлэх эрсдэлтэй өсвөр насны охидыг нөхөн сэргээх, нийгэмшүүлэх зорилготой ажиллаж байна. Бэлгийн мөлжлөгт өртсөн охидыг нөхөн сэргээх арга барил орон нутагт тэр бүр сайн хөгжөөгүй байдаг. Дорнод аймгийн энэхүү сайн туршлага нь цар хүрээгээрээ Улаанбаатартай харьцуулахад харьцангуй бага боловч орон нутагт гарсаар байдаг хүүхдийн эрхийн эсрэг ноцтой гэмт хэргийг илрүүлж, хүүхдэд ээлтэй, хүүхдийн эрхэд суурилсан арга хандлагаар шийдвэрлэхийн төлөө ажилласан туршлага юм (Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 6-аас үзнэ үү).

Охидын төв нь хөдөлмөр эрхэлдэг, эсвэл бэлгийн мөлжлөгт өртсөн болон хөдөлмөр эрхлэх эрсдэлтэй охидод сэтгэл зүйн зөвлөгөө, амьдрах ухаан, эрүүл мэнд, чадавхижуулах сургалтуудыг зохион байгуулж байна. Мөн хүүхдийн эсрэг гэмт хэргийг хүүхдэд ээлтэйгээр мөрдөн шалгах, шийтгэхэд төвийн үйл ажиллагаа анхаарал чиглэж байна.

Боловсролоор дамжуулан хүүхдийг хөдөлмөрөөс хөндийрүүлэх, урьдчилан сэргийлэх

Тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрөөс хөндийрсэн хүүхдийн сурах боломжийг хангасан шинэлэг шийдэл. Дорноговь аймгийн Айраг сумын сургууль сумын төвд амьдардаг ядуу айлын, хичээлээ таслан эсвэл сургуулиас завсардан жоншны уурхайд ажилладаг хүүхдүүдийг хүнд, аюултай хөдөлмөрөөс нь хөндийрүүлж, сургуульд суралцахад нь дэмжлэг үзүүлсэн шинэлэг санаачилга гаргажээ. Тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлдэг хүүхдийг сургуульд нь буцаан суралцуулах, сургуулиас нь завсардуулахгүй байх зорилгоор сумын төвд гэртээ амьдардаг боловч амьдралын боломжгүй, хүнд нөхцөлд байгаа сурагчдыг сургуулийн дотуур байранд суулгаж, сурах таатай нөхцөл боломжоор хангаж байна. Мөн гэртээ амьдардаг боловч амьдралын боломж муутай, хоол хүнсний дутагдалтай зарим хүүхдийг дотуур байрандаа хооллож байна. Эдгээр арга хэмжээ нь хүүхдийг хөдөлмөрөөс хөндийрүүлэхэд их үр нөлөөтэй арга хэмжээ болжээ (Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 7-оос үзнэ үү).

Хүүхдийн түүх: Биеийн тамирын багш болно

Өөрийн гэсэн гэр оронгүй тул Б. охин ээж, аав, ахтайгаа сумын төвд айл хэсч амьдардаг. Аав, ээж нь эрхэлсэн тодорхой ажилгүй. Ах нь долдугаар ангиас, Б. охин тавдугаар ангиас сургууль завсардсан. Амьдрахын эрхээр Б. охин ахтайгаа хамт хөдөө байдаг хамаатныхаа малыг маллаж, бор ходоодоо борлуулж байжээ. Төслийн дэмжлэгтэйгээр Б. охин ахынхаа хамт дотуур байранд суух болж, албан бус боловсролын сургалтад хамрагдаж, улмаар ерөнхий боловсролын сургуульдаа эргэн орж амжилттай суралцаж байна. Охин хичээлдээ шамдахын зэрэгцээ чөлөөт бөхийн дугуйланд хичээллэж, сум, аймаг, бүсийн олон тэмцээнд удаа дараа амжилттай оролцож, зургаан медалиар шагнагдаад байна. Цаашид Б. охин биеийн тамирын багш болж, олон сайхан алдартай бөх бэлтгэж, тэднээрээ бахархаж явах хүсэл мөрөөдөлдөө хөтлөгдөн завгүй явна.

Сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалт. Улаанбаатар хотын захын дүүргүүдийн гэр хороололд ядуу иргэдийн дийлэнх нь амьдардаг, тэдний хүүхдүүд цэцэрлэгт хамрагдаж чаддаггүй. Хотын захын хороололд СӨБ-ын хүртээмж ч хангалтгүй байдаг. Гэр Бүл Хөгжлийн Төв ТББ нь Улаанбаатар хотын гэр хороололд амьдардаг, хөдөлмөр эрхэлдэг, ах эгчээ дагаад сургуульд хамрагдахгүй байх эрсдэлтэй бага насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалтад хамруулж, улмаар тэднийг ерөнхий боловсролын сургуульд оруулах, сургууль завсардахаас урьдчилан сэргийлэх ажлыг нийслэлийн Баянзүрх дүүрэгт АЙПЕК хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр 2004 оноос тууштай хэрэгжүүлж ирсэн юм. Энэ санаачилгыг 2007-2009 онд улам өргөжүүлж төвийн дэргэд байгуулсан “Янзагахан” цэцэрлэгийн байнгын сургалтын ангиас гадна “Бямба, Ням гаригийн анги”-ийг нээн ажиллуулж, илүү олон хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгож байна. Түүнчлэн энэхүү Бямба, Ням гаригийн хувилбарт сургалтын ангийг Сүхбаатар дүүргийн 130 дугаар цэцэрлэгтэй хамтран нээн ажиллуулж туршжээ. Бямба, Ням гаригийн хувилбарт сургалтын ангийг нээн ажиллуулснаар цэцэрлэгийн анги танхимыг бүрэн ашиглаж, зардал багатайгаар, цаг хугацаа хэмнэж, хүүхдэд энгийн сургалттай ижил түвшний чадвар олгож байгаа юм. Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн дагуу нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын санхүүжилтийн хүрээнд багшийн цалинг олгож байна. Энэхүү туршлагыг аль ч сум, дүүргийн цэцэрлэгийн байр, ажиллах хүчнийг ашиглан зохион байгуулах боломжтой. Ингэснээр олон хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулах боломж нэмэгдэнэ.



СӨБ нь хүүхдийн оюун санаа, хэл яриаг хөгжүүлж, суралцах чадавхийг нь дэмжин, ерөнхий боловсролын сургуульд ороод амжилттай суралцахад чухал үүрэгтэй байдаг. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй хүүхдүүд хичээлээсээ хоцрох, улмаар эцэг эхийн дэмжлэг сул бол сургууль завсардах тохиолдол олонтаа тохиолддогийг урьдах сургамж харуулсан билээ. Тиймээс нэн ядуу өрхийн бага насны илүү олон хүүхдийн суралцах боломжийг нь нэмэгдүүлсэн энэ

туршлага бол СӨБ-ын хүртээмжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэх эрсдэлтэй бага насны хүүхдийг сургуульд оруулах үр дүнтэй санаачилга юм. Энэ санаачилгын нэг чухал хэсэг нь сургалтад ашиглаж байгаа “Эрдмийн алтан хаалга” сургалтын багц юм. Сургалтын багц, үйл ажиллагааны туршлагаа хуваалцах, түгээх талаар мөн нэлээд анхаарч ажиллажээ. (Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 8-аас үзнэ үү)

Урлаг, бүтээлч ажиллагааны туслалцаатайгаар хөдөлмөр эрхэлдэг хүүхдийг чадавхижуулах

Чөлөөт цагийн “Цоглог клуб” ба “Цоглог зуслан”. Хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдэд чөлөөт цаг хомс олддог ч түүнийг үр бүтээлтэй өнгөрөөх боломж хязгаарлагдмал байдаг. Нийслэлийн худалдааны зах дээр ажилладаг хүүхдийн хөгжих, нийгэмшихэд нь туслах зорилгоор Тэгш мөр төв, Хүүхэд Залуучуудын Хөгжил Хамгаалал Төв хамтран АЙПЕК хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Баянзүрх захын ойролцоо чөлөөт цагийн “Цоглог клуб”-ыг байгуулсан юм. Энд хүүхдүүд бүжиг, тулааны спорт, фото зураг, тоглоом, дуу, шүлэг,



сургалт, хэлэлцүүлэг зэрэг олон төрлийн үйл ажиллагаа, дугуйланд хамрагдсанаар хүүхдүүд өөрийгөө үнэлэх, өөртөө итгэх, зөв зан үйлийг хөгжөөх, бусдыг хүндэтгэх, бусдад итгэх итгэл нь нэмэгдэж, өөрийгөө илэрхийлэх, бусадтай харилцах чадвар нь сайжирсан байна. Хамгийн гол нь хүүхдүүд ирээдүйгээ сайнаар төсөөлөх болсон нь тэдний суралцах эрмэлзэл нэмэгдэх, аюултай хөдөлмөрөөс хөндийрэхэд ихээхэн хувь нэмэр оруулжээ (Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 9-өөс үзнэ үү).



Төсөлд хамрагдсан хүүхдийг нэлээд хэсэг хугацаа өнгөрсний дараа төслийн багийн зүгээс “Цоглог” клуб дээрээ урьж ирүүлэн, амьдрал ахуй, ажил сургуулийнх нь талаар ярилцаж, зөвлөгөө өгөхийн зэрэгцээ интернет ашиглах, и-мэйл хаяг нээж харилцах сургалтыг явуулсан нь тэдний хэрэгцээ, сэтгэлд маш их нийцэж, эргээд төслийн баг, багш нартайгаа холбоотой байхад чухал нөлөө үзүүлсэн арга хэмжээ болжээ.

Зуны цагт хүүхдүүдийг “Цоглог зуслан”-д ая тухтай амрахын зэрэгцээ тэдний эрүүл мэнд, хүүхдийн эрх, хүүхдийн хөдөлмөр, хүний наймааны тухай ойлголт нэмэгдүүлэх сургалтад хамруулахдаа хүүхдийн урлах, дүрслэх, санаагаа илэрхийлэх, бүтээлчээр хандах чадварыг хөгжүүлж байна.

Уурхай, албан бус хэвшил дэх хүүхдийн хөдөлмөрийг устгахад олон нийтийг идэвхжүүлэх

Алт, жоншны албан бус уурхайд хүүхэд хүнд, аюултай хөдөлмөр эрхэлж байгаа нь хөдөө орон нутагт оршиж буй хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн нэг юм. Малаа алдсан, орлого багатай ядуу, алтны уурхайн ойролцоо амьдардаг өрхийн хүүхдүүд уурхайд ажилладаг. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн төвлөрөл бий болсон газар илүү олон тооны хүүхэд ажилладаг.

Баянхонгор аймгийн туршлага. Алтны уурхайд албан бусаар ажилладаг хүмүүстэй хамтарч ажиллахад түвэгтэй, тэдний итгэлийг нь олоход цаг, хүч их шаарддаг гэсэн ойлголт түгээмэл байдаг. Гэвч Баянхонгор аймгийн туршлага энэхүү тогтсон ойлголтыг өөрчлөхөд хувь нэмэр орууллаа. Албан бус аргаар алт олборлогч иргэд хамтран ажиллаж, тэднийг идэвхжүүлэх замаар хүүхдэд аюултай хөдөлмөрийн тухай ойлголтыг нь нэмэгдүүлж, хүүхдийн хөдөлмөрийг таслан зогсооход тэдний оролцоог нэмэгдүүлэн, улмаар өөрсдийнх нь өмнө тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд хүчийг нь дайчилж, зохион байгуулалтад оруулсан сайн туршлага болжээ. Албан бусаар алт олборлож буй иргэдийн дундаас сайн дурын идэвхтнүүдийг өөрсдийнх нь оролцоотой сонгон, ойлголт нэмэгдүүлэх сургалт сурталчилгааны ажлыг хамтран төлөвлөж явуулсан нь иргэдийг идэвхжүүлэх, ойлголцох, хамтран ажиллах үндсийг тавьсан байна.

Албан бус аргаар алт олборлодог иргэдийг идэвхжүүлж, нэгтгэсэн нь



Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Засаг дарга, сургуулийн захиргааны дэмжлэгтэйгээр алтны уурхайд хөдөлмөр эрхэлдэг 134 хүүхдийг сумын төвд албан бус сургалтад хамруулснаас 83 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд дэвшин суралцаж, 13 хүүхэд мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн

төвд суралцаж байна. Зуны улиралд хүмүүс олноороо албан бусаар алт олборлодог “Алтан Ус” хэмээх газарт сургалтын гэр төв ажиллуулахад сургалтын гэр, сандал ширээг сургуулийн захиргаа болон сумын ЗДТГ гаргасан. Сургуулийн албан бус боловсролын багш алтны уурхай дээрх гэр сургуулийн багшаар ажиллав. Хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдэд хичээл зааж, тэднийг хөгжүүлэх сургалт явуулснаас гадна тэрээр уурхайн орчим суурин амьдардаг алт олборлогч, тэдэнд үйлчилгээ үзүүлэгч 18 айлтай зөвшилцөн зарим газрын ухсан нүхийг эргэж булах ажилд хандив цуглуулж, нүх булах ажилд шаардагдах тос, бензиний зардлыг гаргуулжээ. Улмаар бусад алт олборлогчид нүх булах ажлыг хүчээ нэгтгэн хийж, нийт таван га газар нөхөн сэргээлт хийсэн нь хүмүүс төслийн зорилт, үйл ажиллагааг ихээхэн дэмжсэн төдийгүй хүүхдийн хөдөлмөрийг устгахад чиглэсэн үйл ажиллагаа нь илүү өргөн хүрээний асуудлыг шийдвэрлэх хамтын ажиллагааг бий болгож чаджээ.

Баянхонгорын туршлага нь албан бус уурхайчидтай хамтарч, тэдний эрэлт хэрэгцээнд нь тулгуурлаж ажилласнаар богино хугацаанд үр дүнд хүрч чадна гэдгийг нотолж байна. Тухайлбал, “Алтан ус” гэдэг газар ажиллуулсан албан бус сургалт, мэдээллийн “Гэр төв”-ийн сургалт, танин мэдэхүйн үйл ажиллагаанд алт олборлогчид хүүхдүүдээ бүрэн хамруулж, эцэг эхчүүдэд зориулсан сурталчилгаа, ойлголт нэмэгдүүлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байв. Эцэг эхчүүд хүүхдүүдээ сургуульд суралцуулах хүсэлтэй болж, нүх ухуулах, газар дор ажиллуулахыг зогсоожээ. Хүүхдийг газар дор ажиллуулахгүй байхад сайн дурын идэвхтнүүд чухал үүрэг гүйцэтгэжээ (Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 10-аас үзнэ үү).

Хүүхдийн түүх: Би гутлын дизайнер болно



Алтны уурхайд ажиллах ёстой хэцүү. Нүх ухаж, шороо зөөж, хүрздэж шидэхэд шөнө нь нуруугаар хөшиж бөөр өвддөг. Бөөр одоо ч өвддөг хэвээрээ. Тэгээд шороо тоос ам руу орж, хээр гадаа нүхэнд унтаж, өлсөх хэцүү. Энэ төслийн ачаар би тэр муухай газраас холдож, одоо МСҮТ-ийн гуталчны ангид суралцаж байна.

Намайг ийм хэцүү амьдралаас минь салгаж, өөртөө итгэлтэй болоход минь тусалсан багшдаа болон дэмжлэг үзүүлсэн ах эгч нартаа баярлалаа. Би сайн мэргэжилтэн болоод эх орондоо хэрэгтэй сайн зүйлийг хийнэ ээ.

Хүүхдийн түүх : *Шороо ухсанаас сурах нь хамгийн гоё гэж бид ярилцдаг*

Намайг Ц. гэдэг. Би сургалтад хамрагдахаасаа өмнө алтны шороонд явдаг байсан. Ингэж явахдаа их даардаг, нүх ухах, шороо үүрэх хамгийн хэцүү. Өлсөнө, даарна, олсон мөнгөөрөө идэж уух юм, өмсөх хувцас аваад л дуусчихдаг. Би ерөөсөө сургуульд сурч байгаагүй, сургуульд сурах юмсан, найзуудтай болох юмсан гэж их боддог байсан. Албан бус сургалтаа төгсөөд МСҮТ-ийн мужааны ангид амжилттай суралцаж байна. Надтай ижил алттай газарт ажилладаг, зах дээр гурил үүрдэг зөндөө олон хүүхэд албан бус сургалтад суралцсан. Шороо ухсанаас сурах нь хамгийн гоё гэж бид ярилцдаг. Энэ төсөлд хамрагдаад би бичиг үсэг сурч, найзуудтай болж, мэргэжил эзэмшиж, цаашид их зүйлийг сурч мэдэх эрмэлзэлтэй болсондоо үнэхээр баяртай байгаа.



Худалдааны захын удирдлага, ажилтнуудын ойлголтыг дээшлүүлсэн туршлага. Албан бус хэвшилд хөдөлмөр эрхэлдэг хүүхдийн дийлэнх нь худалдааны зах дээр ажилладаг. Тэгш мөр төв ТББ нь АЙПЕК хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр нийслэлийн хэд хэдэн томоохон худалдааны зах дээр хүүхдийн хөдөлмөрийг устгахад захын удирдлага болон ажиллагсад, түрээслэгч нартай олон чиглэлээр хамтран ажилласан байна. Төсөлд

хамрагдсан зах бүр дээр захын удирдлага, ажилтнууд, тэнд хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдтэй хамтран оролцооны аргаар хэлэлцэх замаар хүүхдэд хамгийн аюултай, хортой газруудыг тодорхойлж, тэдгээрийг “Хүүхдийн хөдөлмөргүй орчин” болгох зорилтын төлөө төслийн баг, захын удирдлага хамтран ажиллажээ. Үүний тулд ухуулга сурталчилгаа, хүүхдийн хөдөлмөрийн мониторинг зэрэг олон чиглэлээр захын удирдлага, ажиллагсадтай хамтран ажилласан байна. Үүний үр дүнд “хүүхдийн хөдөлмөргүй орчин” гэж тэмдэглэгдсэн газруудад хүүхэд аюултай ажил эрхлэх нь эрс буурч, худалдааны захын удирдлагууд хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг нэг ажилтандаа хариуцуулж ажилладаг болжээ. Аж ахуйн нэгж байгууллагууд нийгмийн хариуцлагаа мөнгөн хандиваар бус, өөр бусад хэлбэрээр ч хэрэгжүүлэх чадвартайг энэ туршлага харуулж байна (Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 11-ээс үзнэ үү).

Хүүхдийн түүх: Би дээд сургуульд сурахыг хүсдэг

Би Да хүрээ зах дээр машин харах ажил хийдэг байсан. Аав цэргийн ангид ажиллаж байгаад группэд гарсан, ээж аавыг асраад ажилгүй, аавынх группын мөнгөөр л амьдардаг тул хичээлд явахын хажуугаар Цайз, Да хүрээ зах дээр жижиглэнгийн бараа зардаг, шөнө нь машин хардаг байлаа. Хоёр дүү маань ЕБС-д сурдаг. Олсон орлогоороо өдрийн хоол ундаа авдаг, аавдаа эм тариа авч өгөх, түлээ нүүрсээ авах, мөн дүү нарынхаа хичээлийн хэрэглэлийг авч өгөхөд тусалдаг байсан. Олсон мөнгө маань хаанаа ч хүрэлцдэггүй байсан. Шөнө нь машин харж хоноод өглөө нь хичээлдээ явахад маш их ядардаг тул хичээлээ их тасалдаг, тэгээд сургуулиас завсардсан юм.

Би хэдийгээр хөдөлмөр эрхэлдэг, манай амьдралын түвшин муу ч гэсэн төслийн дэмжлэгтэйгээр албан бус сургалтанд суралцаж, дараа нь ЕБС-д эргэж ороод, сургуулиа төгссөн. Дээд сургуульд сурах хүсэл маш их байгаа боловч төлбөр төлөх боломж байхгүй учраас нэгэн байгууллагад илгээмж түгээгчээр ажиллаж байна. Сарын цалин маань 180.000 төгрөг. Хоёр дүү маань нь сургуульдаа тогтмол явж байгаа. Цаашид дээд сургуульд сурч сайн ажил хийх, сайхан амьдрахыг чин сэтгэлээсээ хүсдэг тул тэтгэлэгт хөтөлбөрүүдийн уралдаанд оролцож байна (А, одоо 19 настай)

БҮЛЭГ 5. ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН МОНИТОРИНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЙН ТУРШЛАГА



Хүүхдийн хөдөлмөрийн мониторинг (ХХМ) нь хөдөлмөр эрхэлдэг хүүхдийг илрүүлэх, тэднийг нийгмийн үйлчилгээнд хамруулах замаар хөдөлмөрөөс нь хөндийрүүлэх, улмаар дахин хөдөлмөр эрхлэхээс сэргийлэхэд хяналт тавих гэсэн харилцан уялдаатай үе шатаас бүрдсэн үйл ажиллагаа юм. ХХМ-ийг орон нутгийн холбогдох байгууллагын ажилтан, хөдөлмөрийн байцаагч, иргэд, сайн дурын идэвхтнүүд гэх мэт нийгмийн олон төлөөллийн

хамтын хүчин чармайлтад түшиглэн хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй байдаг.

Нийслэлийн Налайх дүүрэг дэх хүүхдийн хөдөлмөрийн мониторингийн сүлжээ. Хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийг илрүүлэх, үйлчилгээнд хамруулах, урьдчилан сэргийлэх мониторингийг зөвхөн ажлын байранд бус, сургууль, амьдарч байгаа газарт нь өргөжүүлэн хэрэгжүүлснээрээ Налайх дүүрэг бусад газрын адил төстэй санаачилгуудаас онцлог юм. Ажлын төрлөөр авч үзвэл нүүрсний уурхай, тоосгоны үйлдвэр дэх хүүхдийн хөдөлмөрийг устгахад илүүтэй анхаарал хандуулжээ. Налайх Дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулсан дүүргийн мониторингийн баг нь дүүргийн нутаг дэвсгэр дээрх нүүрсний уурхай, тоосгоны үйлдвэр зэрэг газар дахь хүүхдийн хөдөлмөрт хяналт тавьдаг бол хороодын Засаг даргын захирамжаар байгуулагдсан хорооны баг нь тухайн хорооны нутагт дэвсгэрт хөдөлмөр эрхэлдэг болон эрхлэх эрсдэлтэй хүүхдийг илрүүлэх, үйлчилгээнд хамруулах үүрэгтэй. Түүнчлэн сургуулийн мониторингийн баг нь хүүхэд сургууль завсардах, хичээлээс гадуур хөдөлмөр эрхлэхээс сэргийлэхэд анхаардаг.

Ийнхүү хүүхдийн хөдөлмөрийн мониторингийн сүлжээг байгуулснаар дүүрэг, хороо, сургуулиуд хоорондоо мэдээлэл солилцох, хамтран ажиллах явдал нэмэгдэж, хүүхдийг аюултай хөдөлмөрөөс хөндийрүүлэх, нөхөн сэргээх, эцэг эх, гэр бүлд нь дэмжлэг үзүүлэх, дахин аюултай хөдөлмөр эрхлэх, сургууль завсардахаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны уялдаа сайжирчээ (Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 12-оос үзнэ үү).

Дорнод аймгийн сумдад хэрэгжүүлсэн хүүхдийн хөдөлмөрийн мониторинг. Хүүхдийн хөдөлмөрийн мониторингийг хэрэгжүүлэх, чадавхи бэхжүүлэх сургалтын дараа аймгийн төв болон сумдад хүүхдийн хөдөлмөрийн мониторинг хийх ажлыг зохион байгуулж, хүүхдийн хөдөлмөрийг таслан зогсооход үр дүнд хүрчээ. Тухайлбал, Цагаан-Овоо суманд бага насны хүүхдүүд мал нядалгааны газар ажиллаж байсныг сумын ХХМ-ийн баг зогсоосон байна. Уг нядалгааны газарт арилжааны зорилгоор мал нядлахаас гадна айл өрхүүд өвлийн идшээ бэлтгэхдээ бага насны хүүхдийг ажилд зардаг явдал нийтлэг байв. Улай, нядалгааны бөөний цэг дээр хүүхэд ажиллах нь зохисгүй, тэдний сэтгэл зүйд сөргөөр нөлөөлнө гэж үзсэн тул сумын ХХМ-ийн багаас сумын иргэд, хүүхдийн эцэг эхтэй уулзах, ухуулга хийж, улмаар мал нядалгааны цэг

дээр хүүхэд ажиллуулахгүй байх талаар сумын Засаг дарга захирамж гарган, уг захирамж хэрхэн хэрэгжиж байгаад байнгын хяналт тавьсны үр дүнд нядалгааны газар бага насны хүүхдүүд ажиллахаа больжээ.

Өвөрхангай аймгийн албан бус алтны уурхай дахь дэмжигч бүлгүүд.

Сумдын хүүхэд хамгааллын багийн дэргэд хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхэлдэг хүүхдийг илрүүлэх, тэдний талаар хүүхэд хамгааллын багт мэдээлэх үүрэгтэй дэмжигч бүлгүүд байгуулагджээ. Дэмжигч бүлгүүд нь сайн дурын идэвхтэн, эцэг эх, багш, хүүхдүүдээс бүрдэж байгаа бөгөөд хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагаа зорилтот бүлгийн хүүхэд, иргэдэд хүрэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Уянга сумын Өлтийн алтны албан бус уурхайд ажилладаг иргэдийн тоо зуны улиралд 5000 гаруй болж өсдөг. Албан бус аргаар алт олборлогч иргэдээс таван эмэгтэйг өөрсдийнх нь саналыг харгалзан сайн дурын идэвхтнээр сонгон, уурхай дээр ажилладаг хүүхдүүдийг илрүүлж, тэднийг уурхай дээр ажиллуулж буй албан бус сургалтын багш дээр авчрах, иргэдийн дунд сургалт сурталчилгаа явуулах, алт олбоорлогчдыг олон нийтийн ажилд татан оролцуулах үүрэгтэй ажиллуулжээ. Энэ таван эмэгтэй нь уурхайн орчимд олон жил гэр бүлтэйгээ хамт суурьшин амьдарсан бөгөөд үр хүүхдийг нь хамгаалах, хүнд хөдөлмөрөөс хөндийрүүлж, боловсрол эзэмшүүлэхэд чиглэсэн төслийн үйл ажиллагаа, зорилтыг дэмжин ажиллаж байна. Сайн дурын идэвхтэн эмэгтэй тус бүр уурхай дээр ажилладаг 20-30 хүүхдийг илрүүлэн, мэдээлж, гэр сургуульд хамруулахад шууд нөлөөлжээ.



Хавсралт 1. ХХТХ-үүдийг устгахад чиглэсэн орон нутгийн хэмжээний үйл ажиллагааны загвар (2006 онд боловсруулсан хувилбар)

Үйл ажиллагааны зарчим:

- Цогц, харилцан уялдаатай байх
- Бодлого, бүтэц, санхүүжилттэй уялдах
- Хүүхдийг хөдөлмөрлөхөөс урьдчилан сэргийлэхэд ач холбогдол өгөх
- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгахад нэн тэргүүнд анхаарал хандуулах
- Гурван талт түншлэл, хамтын ажиллагаанд тулгуурлах
- Албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилттэй уялдсан байх
- Хүүхдийн эрхийг хүндэтгэх, хувийн нууцыг хамгаалах

Загварын бүрэлдэхүүн хэсэг:

- Бодлого, зохицуулалт, хэрэгжүүлэлт, чадавхи бүрдүүлэлт
- Олон нийтийн ойлголт, хандлага
- Мэдээлэл, судалгаа
- Хүүхдийн хөдөлмөрийн мониторинг
- Тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрөөс хүүхдийг хөндийрүүлэхэд чиглэсэн шууд туслалцаа
- Хууль сахиулалт
- Нийгмийн түншлэл, хамтын ажиллагаа

Бүрэлдэхүүн хэсгийн стратеги

1. Бодлого, зохицуулалт, хэрэгжүүлэлт, чадавхи бүрдүүлэлт

- ХХТХ-ийг устгахад чиглэсэн аймгийн хэмжээний бодлого, стратеги, үйл ажиллагаа тодорхой болсон байх, тухайн орон нутгийн онцлог, нөхцөл байдлыг харгалзан үзсэн байх
- Аймгийн хэмжээний бодлогын хэрэгжилтийг зохицуулан, удирдлагаар хангах, үнэлгээ дүгнэлт хийх гурван талт бүтэц, механизмыг бий болгох, чиг үүргийг тодорхой болгох, хэвшүүлэх
- ХХТХ-үүдийг устгах зорилтыг эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр, нийгмийн хамгааллын байгууллага, ядуурлыг бууруулах үйл ажиллагааны анхаарлын төвд байлгах
- Бодлого, стратегийг хэрэгжүүлэх ажилтнуудын ойлголт, чадавхийг дээшлүүлэх, тэдний үүрэг, оролцоог тодорхой болгох

2. Олон нийтийн ойлголт, хандлага

- ХХТХ-үүдтэй тэмцэхэд чиглэсэн компанит ажил, цуврал арга хэмжээг зохион байгуулж хэвшүүлэх
- Жил бүрийн 6 дугаар сарын 12-ны өдөр буюу Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг Дэлхийн өдрийг үндэсний хэмжээний зорилт, уриалгын хүрээнд болон тухайн орон нутгийн онцлогийг харгалзан үзсэн байдлаар зохион байгуулж тэмдэглэх
- Зорилтот бүлгүүдийн ойлголтыг нэмэгдүүлж, хандлагыг өөрчлөхөд тусгайлсан стратеги боловсруулж хэрэгжүүлэх
- Олон нийтийн ойлголт дээшлүүлэх ажлыг дэмжих бүлгүүдийг бий болгох, чадавхижуулах
- Олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх ажилд нийгмийн түншүүдийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх
- Орон нутгийн хэвлэл мэдээллийн ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэх

3. Мэдээлэл, судалгаа

- Хөдөлмөр эрхэлдэг хүүхдийн тухай мэдээллийг цуглуулахдаа төрийн байгууллагуудын зүгээс цуглуулдаг мэдээллийн хүрээнд нэгтгэхийг чармайх, мэдээллийн үзүүлэлтийг оновчтой, боловсронгуй болгох
- Орон нутгийн түвшин дэх мэдлэгийг дээшлүүлэхийн тулд хүүхдийн хөдөлмөрийн тодорхой хэлбэрүүдийн шинж байдлыг судалдаг байх
- Гаргасан мэдээлэл, судалгааг олон нийтэд таниулдаг байх, үр дүнг нь бодлого, үйл ажиллагааг боловсронгуй болгоход ашиглах

4. Хүүхдийн хөдөлмөрийн мониторинг

- Хүүхдийн хөдөлмөрийн мониторингийг эрсдэлтэй, мөлжлөг агуулсан салбарт нэн тэргүүнд бий болгож хэвшүүлэх
- Хүүхдийн хөдөлмөрийн мониторингийн мэдээллийн үр дүнд хүүхдийг нийгмийн үйлчилгээтэй холбодог болох
- Хүүхдийн хөдөлмөрийн мониторингиор цуглуулсан мэдээлэл нь үндэсний хэмжээний мониторингийн системд ашиглагддаг байх

5. Тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрөөс хүүхдийг хөндийрүүлэхэд чиглэсэн шууд туслалцаа

- Шууд туслалцааны үйл ажиллагааг төлөвлөхдөө мэдээлэл дээр тулгуурлах, зорилтот бүлэг, олон нийтийн оролцоог хангах
- Тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдэд нэн тэргүүнд анхаарлаа хандуулж, тэдний хэрэгцээг оновчтой тодорхойлсны үндсэн дээр хөдөлмөрөөс хөндийрүүлэх, нөхөн сэргээх
- Тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж болзошгүй хүүхдийг илрүүлэн урьдчилан сэргийлэх
- Насанд хүрээгүй хүн эрхлэхийг хориглосноос бусад төрлийн ажлыг эрхэлдэг хүүхдийн ажлын нөхцлийг сайжруулах (гэрээ, хөлс, хамгаалалт г.м)
- Ажил эрхлэх насанд хүрсэн хүүхдийг хөдөлмөрийн зах зээлд бэлтгэхэд анхаарах
- Хүүхэд, тэдний гэр бүлд чиглэсэн нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх (халамж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ядуурлыг бууруулах, эрүүл мэнд,

боловсрол, иргэний бүртгэл мэдээлэл, засаг захиргааны анхан шатны үйлчилгээ г.м.)

- Эцэг эх, өрхийн насанд хүрсэн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар хүүхдийн хөдөлмөрийг бууруулах, өрхийн орлогыг нэмэгдүүлэх

6. Хууль сахиулалт

- Хүүхдийн хөдөлмөртэй холбогдолтой хууль тогтоомжийн биелэлтийг сахиулагч орон нутгийн байгууллага, ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх, хууль хэрэгжүүлэх, орон нутгийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх
- Хүүхдийн хөдөлмөртэй холбогдолтой хууль тогтоомжийг олон нийтэд байнга сурталчлах
- Хууль, тогтоомжийн зөрчил арилгасан талаарх сайн жишээг олон нийтэд мэдээлэх, бусдад түгээн дэлгэрүүлэхийг дэмжих

7. Нийгмийн түншлэл, хамтын ажиллагаа

- Орон нутгийн хэмжээний нэгдмэл үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ажил олгогчдын төлөөллийн байгууллага, үйлдвэрчний эвлэлүүдийн гүйцэтгэх үүрэг, оролцоог нэмэгдүүлэх
- ХХТХ-дийг устгахад орон нутгийн захиргаа, эзэд, үйлдвэрчний эвлэлийн хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих
- Холбогдох төрийн бус байгууллагуудтай холбоо тогтоох, үйл ажиллагаанд татан оролцуулах, тэдний давуу талыг ашиглах
- Эзэд, ажиллагчдын төлөөлөгчид, хувийн хэвшлийнхэн, ТББ-уудын ажилтнуудын чадавхийг дээшлүүлэх

Хавсралт 2. ХХТХ-дийг устгах орон нутгийн нэгдмэл үйл ажиллагааны загварын давуу тал

1. Цогцоор хандах

Орон нутгийн дэд хөтөлбөрийн төлөвлөлт нь ОННҮАЗ-ын стратегитэй нэлээд дүйцсэн байна. Тухайлбал ХХТХ-тэй тэмцэх, устгах асуудлыг Засаг даргын мөрийн хөтөлбөр болон нийслэл, аймгийн нийгэм эдийн засгийн үндсэн чиглэлд тусгах, ХХТХ-үүдийг устгах орон нутгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх, бусад бодлого хөтөлбөрийн хэрэгжилттэй уялдуулах зорилгоор салбар хоорондын ажлын хэсгийг байгуулан үүрэг хариуцлагыг нь Засаг даргын захирамжаар баталгаажуулах, холбогдох байгууллага ажилтнуудын чиг үүрэг, ажлын байрны тодорхойлолтод суулгах зэрэг үйл ажиллагаа нь Загварын нэгдүгээр бүрэлдэхүүн хэсгийн стратегийг хэрэгжүүлэх хүрээнд хийгджээ. Түүнчлэн хэвлэл мэдээллийнхэнтэй гэрээ байгуулж, олон нийтийн ойлголт нэмэгдүүлэхэд чиглэсэн нэвтрүүлэг мэдээ, баримтат кино бэлтгэх, нэвтрүүлэг, сурталчилгааны материал боловсруулах, тараах, Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг Дэлхийн өдрийг тэмдэглэж хэвших зэрэг үйл ажиллагаа нь загварын хоёрдугаар бүрэлдэхүүн хэсгийн стратегийн хүрээнд, хүүхдийн хөдөлмөрийн мэдээллийн сан бий болгох чиглэлээрх сургалт, хүүхдийг бүртгэлжүүлэх ажлыг гуравдугаар бүрэлдэхүүн хэсгийн стратегийн хүрээнд, олон нийтэд суурилсан мониторингийн багийг бүрдүүлж ажиллуулах ажлыг дөрөвдүгээр бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд, боловсрол, урлаг, амьдрах ур чадварын сургалт, хууль эрх зүй, сэтгэл зүйн үйлчилгээ зэргээр дамжуулан хүүхдэд чиглэсэн нөхөн сэргээх, хөндийрүүлэх, хамгаалах үйл ажиллагааг тавдугаар бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд, хууль тогтоомжийг мөрдүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг зургаадугаар бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд, гурван талт түншлэлийн гэрээнд хүүхдийн хөдөлмөрийг устгах асуудлыг тусгах, гурван талын хамтын ажиллагааг хөгжүүлэх үйл ажиллагааг долдугаар бүрэлдэхүүн хэсгийн стратегийн хүрээнд тус тус төлөвлөн хэрэгжүүлжээ.

Хүүхдийн хөдөлмөрийг бууруулах зорилт урьд нь хүүхдийн хөдөлмөрийг бууруулах гэсэн ерөнхий ганц өгүүлбэрээр аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын мөрийн хөтөлбөр болон нийгэм эдийн засгийн үндсэн чиглэлд тусгагдаж байсан бол ОННҮАЗ-ийн стратегитэй холбоотойгоор ХХТХ-үүдтэй тэмцэх орон нутгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх багц бүтээгдэхүүн болж тусгагдсан байна. Улмаар Шадар Сайдтай хийх Засаг даргын үр дүнгийн гэрээнд энэ дэд хөтөлбөр хэрэгжих ёстой ажлын нэг болж тусгагдан, Засаг дарга энэ үүргийг биелүүлэхийн тулд сумдын Засаг даргын мөрийн хөтөлбөрт оруулж үр дүнгийн гэрээ байгуулсан байна. Үүрэг, хариуцлагын энэ уялдаа ялангуяа Баянхонгор, Дорнод, Өвөрхангай аймагт илүү хүчтэй явагджээ. Эдгээр аймаг болон Дорноговь аймагт бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгчдийн болон олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа бүх газарт эрчимтэй явагдсанаар аль ч түвшинд хүүхдийн хөдөлмөрийн талаар зөв ойлголт, хандлага бий болсноос гадна хүүхдийн хөдөлмөр нь олон салбарыг хамарсан цогц асуудал тул ганц байгууллагын оролдлогоор бус олон байгууллага, иргэдийн оролцоотойгоор шийдвэрлэх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрөх хандлага төлөвшжээ.

2. Байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдааг хангах

ОННҮАЗ-ыг хэрэгжүүлснээр хүүхдийн хөдөлмөрийг бууруулах асуудал ганц байгууллагын (голдуу хүүхдийн байгууллага) хүчин чармайлтаас хальж, олон байгууллагын үүрэг хариуцлагад тусгагдсан байдал загвар хэрэгжүүлсэн бүх газарт ажиглагдаж байна. ХХТХ-үүдтэй тэмцэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудлыг хариуцсан салбар хоорондын багийг аймаг, нийслэлийн түвшинд болон сум, дүүргийн (Налайх) түвшинд Засаг даргын

дэргэд байгуулж, ажиллах удирдамж, чиг үүргийг зааж өгчээ. Салбар хоорондын баг нь хүүхэд хамгааллын баг, төслийг хэрэгжүүлэх баг зэрэг өөр өөр нэртэй, тухайн орон нутгийн онцлогоос хамаараад гишүүдийн тоо харилцан адилгүй өөр байгаа ч үндсэн чиг үүрэг, холбогдох бүх салбарын төлөөлөл нь нийтлэг байна.

Ерөнхийд нь дүгнэвэл АЙПЕК-ийн төсөл хэрэгжүүлсэн дөрвөн аймаг, тэдгээрийн сумдын түвшинд ОННҮАЗ-ыг баримтлан төлөвлөлт, зохицуулалтын уялдааг амжилттай ханган ажиллажээ. Харин нийслэлийн хувьд Налайх дүүргийг эс тооцвол ОННҮАЗ-ыг хэрэгжүүлэх ажил дүүргийн түвшинд бүрэн төлөвшиж хараахан чадаагүй боловч загварын ач холбогдлыг нийслэл, дүүргийн түвшинд сайтар ойлгож, хүлээн зөвшөөрөөд байна. Цаашид загварыг нийслэлийн дүүрэг, хороодын түвшинд түгээн дэлгэрүүлэхэд хүчин чармайлт гаргах шаардлагатай юм.

3. Идэвхтэй, өөриймсөг хандах

Тухайн орон нутаг дахь хүүхдийн хөдөлмөрийн тулгамдсан асуудлыг орон нутгийнхан өөрсдөө зөвлөлдөн тодорхойлж, түүнийг шийдвэрлэх стратегийн талаар зөвшилцөж байсан нь орон нутагт идэвхтэй, өөриймсөг хандлагыг бий болгож чаджээ. Тухайлбал, Налайх дүүрэгт нүүрсний уурхай, тоосгоны үйлдвэр дэх хүүхдийн хөдөлмөр, Баянхонгор, Өвөрхангай аймагт мал аж ахуй болон алтны албан бус уурхай, Дорноговь аймагт жоншны албан бус уурхай, төмөр замын өртөөн дэх хүүхдийн хөдөлмөрийг бууруулах, Дорнод аймагт мал аж ахуй болон зах дээр наймаа эрхлэх, ачаа зөөх, мал нядалгааны газар хүүхэд ажиллуулахыг зогсоох, түүнчлэн охидыг бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх зэрэгт анхаарлаа нэн тэргүүнд хандуулжээ.

ОННҮАЗ нь багаараа хамтарч, нээлттэй ажиллах зарчимд тулгуурласан тул сонирхолтой санал санаачилгуудыг ихээхэн дэмжсэн байна. Тухайлбал, Өвөрхангай аймгийн Засаг даргын 2008 оны захирамжаар “Аймгийн сайн малчин” шалгаруулах болзолд хүүхдийн хөдөлмөрийг мөлжих явдлыг таслан зогсооход чиглэсэн нэмэлт тодотгол хийжээ. Уламжлалт мал аж ахуй дээр хүүхдийг хүнд, аюултай нөхцөлд ажиллуулахгүй, тэдний сурч боловсрох эрхийг хүндэтгэж сургуулиас нь хөндийрүүлж завсардуулахгүй байх шалгуур үзүүлэлтийг нэмж оруулсан нь тус аймагт мал аж ахуйн салбарт хүүхдийн хөдөлмөрийн мөлжлөгийг устгахад чухал хөшүүрэг болжээ.

Хавсралт 3. Хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг шийдвэрлэхэд орон нутгийн бодлого зохицуулалт, чадавхийг дээшлүүлсэн нь

Байгууллагын нэр: Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газар

Үндэслэл. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах аймгийн дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх явцад олон байгууллага жигд оролцоотой, нэгдмэл нэг зохион байгуулалттай ажиллах зайлшгүй шаардлагатай болсон. Аль нэг байгууллага, албан тушаалтан дангаараа хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг шийдэх боломжгүй юм байна гэсэн дүгнэлтэд хүрсэн. Тиймээс хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх орон нутгийн нэгдсэн бодлого зохицуулалтыг бүрэн тодорхойлж, бүтэц зохион байгуулалт, шат шатны түвшинд ажилтан албан хаагчдын чадавх, хариуцлагыг өндөржүүлэхэд чиглэгдсэн тогтолцоог бий болгох шаардлагатай байв.

Сайн туршлагыг хэрэгжүүлсэн үйл явц. Шат дараатай арга хэмжээ авч хэрэгжүүллээ. Юуны түрүүнд хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх асуудлыг аймгийн хэмжээний дараахь бодлогын баримт бичигт тусгав. Үүнд:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр (2008-2012), түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
2. Аймгийн Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл (жил бүрийн)
3. Аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчтай, байгууллагын Ерөнхий менежерийн байгуулсан Бүтээгдэхүүн нийлүүлэлт санхүүжилтийн гэрээ, төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээ
4. Шат, шатны төрийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт

Бодлогын баримт бичгүүдэд тусгасан зорилтыг хэрэгжүүлэх талаар авсан тодорхой арга хэмжээний нэг нь аймаг, сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулах “Хүүхэд хамгааллын баг”-ийг Аймгийн Засаг даргын 2009 оны 92 тоот захирамжаар байгуулж, үйл ажиллагааных нь чиглэлийг тодорхойлж өгөв. Аймгийн Хүүхдийн төлөө хэлтэс, Эрүүл мэндийн газар, Боловсрол соёлын газар, Цагдаагийн газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс зэрэг байгууллагууд харилцан санал солилцсоны үндсэн дээр хүүхэд хамгааллын багийг дэмжиж ажиллах хамтын ажиллагааны чиглэлүүдийг тодорхойлж, ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтсээр баталгаажуулж ажиллав.

Хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагааны нэг зорилтот бүлэг нь хөдөлмөр эрхлэгч хүүхдүүд, тэдний гэр бүл байхаар тусгаж өгөв. Хүүхэд хамгааллын багийн дэргэд иргэдийн сайн дурын үндсэн дээр байгуулагдсан дэмжих бүлэг ажиллаж байна. Баг нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, иргэд олон нийтийн оролцоотойгоор зохион байгуулагдсанаараа онцлог юм.

Хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагааг дараахь байдлаар зохион байгууллаа. Үүнд:

- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах аймгийн дэд хөтөлбөрийн ажлын хэсэг эхлээд хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар нэлээд чадваржиж аваад дараа нь тодорхой чиглэлээр тухайлсан албан тушаалтан бүрт чиглэсэн сургалтуудыг хийв. Сумын хүүхдийн эрхийн ажилтан, боловсрол, эрүүл мэндийн нийгмийн ажилтан, албан бус боловсролын багш арга зүйч, сумын Засаг даргын

Тамгын газрын дарга, сумын нийгмийн ажилтанд зориулсан тухайлсан сургалтууд зохион байгууллахын зэрэгцээ, аймагт зохион байгуулагдаж буй бусад сургалтад хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг оруулдаг боллоо.

- Хүүхэд хамгааллын баг нь сумын Засаг даргын ахалдаг сумын Хүүхдийн төлөө зөвлөлийн дэргэд байгуулагдаж улирал тутам үйл ажиллагаагааны үр дүнг зөвлөлийн хуралдаанд тайлагнадаг, үнэлүүлдэг байхаар зохион байгуулсан нь онцлог юм. Баг нь хүүхэд хамгааллын асуудлаар хамтран ажиллах бөгөөд хөдөлмөр эрхэлдэг болон эрхлэх эрсдэлтэй хүүхдийг илрүүлэх, тэдний нөхцөл байдлын үнэлгээ хийх, шаардлагатай дэмжлэг үйлчилгээг төлөвлөх, үйлчилгээнд хамруулах, үр дүнг нь үнэлэх, тодорхой хугацааны дараа хүүхдийн нөхцөл байдалд гарсан өөрчлөлтийг эргэн тооцох зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.
- Хүүхэд хамгааллын багийн амжилттай ажиллах нэг үндэс нь хөдөлмөр эрхэлж байгаа болон эрх нь зөрчигдсөн хүүхдийн тухай мэдээллийг шуурхай олж авах явдал байдаг. Баг нь төрийн албан хаагчдаас бүрдсэн тул хүүхдийн эрхийн зөрчлийн талаарх мэдээллийг тэр бүр шуурхай олох боломж хязгаарлагдмал байв. Тиймээс нутгийн иргэдийн сайн дурын оролцоонд тулгуурласан дэмжих бүлгийг хүүхэд хамгааллын багийн дэргэд байгуулав. Энэхүү дэмжих бүлэг нь хүүхдэд чиглэсэн үйлчилгээ, үйл ажиллагаа явуулахгүй бөгөөд хүүхдийн эрхийн зөрчлийн асуудлаар багийг мэдээллээр хангах үүрэгтэй юм. Нэгэнт мэдээлэл ирсэн тохиолдолд хүүхэд хамгааллын баг шуурхай ажиллаж, хүүхдийн эрхийн зөрчил мөн эсэх, ямар арга хэмжээ авахаа шийднэ.

Үр дүн:

1. АЙПЕК-ийн дэмжлэгтэй төсөл хэрэгжиж дууссаны дараа хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагаагаар дамжуулан хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдтэй тэмцэх үйл ажиллагаа цаашид тогтвортой үргэлжлэх боломж бүрдсэн.
2. Багийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд оруулж танилцуулан, 2010 онд сумын Хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэхэд чиглэсэн болзолт уралдаан зарлаж, шаардлагатай хөрөнгийг Засаг даргын багцаас гаргуулахаар шийдвэрлэсэн.
3. Хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагааны үндсэн тогтолцоонд хүүхдийн хөдөлмөрийн мониторингийн үйл ажиллагааг нэгтгэн багийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх Дэмжих бүлгийг ажиллуулж байгаа нь тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж буй хүүхдийг илрүүлэх, хөдөлмөрөөс хөндийрүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх бодит боломжийг бүрдүүллээ.

Сайн туршлагыг хэрэгжүүлэх нөхцөл:

- Юуны өмнө аймгийн хэмжээнд хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар нэгдмэл нэг ойлголттой болох
- Хүүхдийн хөдөлмөр бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутгийн зохицуулалтууд хийгдсэн байх
- Багийн гишүүд хүүхдийн хөдөлмөрийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, багаар ажиллах чиглэлээр чадавхижсан байх
- Багийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох
- Нутгийн иргэдийн сайн дурын оролцоонд тулгуурласан дэмжих баг ажиллуулах

Сайн туршлагаас гарсан сургамж:

- Багийн үйл ажиллагааны үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг нарийвчлан гаргах шаардлагатай нь ойлгогдсон.
- Орон нутгийн хөндлөнгийн хяналтыг бүрдүүлж, багийн үйл ажиллагааг үнэлж дүгнэх механизм бүрдүүлэх хэрэгтэй байсан.
- Дэмжих бүлгийн гишүүдийг урамшуулах механизм бүрдүүлэх хэрэгтэй болсон.

Сайн туршлагын талаар нэмэлт мэдээлэл өгөх хүмүүс:

- С. Санчир, Аймгийн Хүүхдийн төлөө хэлтсийн дарга, утас 93077111
- Л. Ишханд, Хүүхдийн төлөө хэлтсийн хүүхдийн эрх, нийгмийн хамгаалал хариуцсан ахлах мэргэжилтэн, утас 99881483, э-шуудан ihsee8814@yahoo.com

Хавсралт 4. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүүхдийн эрхийг хангах, хянах тухай Харилцан ойлголцлын санамж бичиг

Байгууллагын нэр: Монголын Хэвлэлийн Хүрээлэн ТББ

Үндэслэл. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийгмийн хөгжлийн асуудлыг олон нийтэд хүргэхэд зай талбай, цагийн хуваарилалт төдийлөн хангалттай байдаггүй. Сэтгүүлчид хүүхдийн асуудал, тэр дундаа хүнд нөхцөлд байгаа, эмзэг бүлгийн хүүхдийн талаар даацтай нийтлэл, нэвтрүүлэг бэлдэх хүсэл байдаг ч нийтлэх нэвтрүүлэх зай талбайнаас болоод төдийлөн хөнддөггүй. Түүнчлэн хэвлэл мэдээллийн байгууллагын эзэд, удирдлагууд эдгээр асуудалд төдийлөн анхаардаггүй. Яагаад гэвэл ихэнх хэвлэл мэдээллийн байгууллага арилжааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Иймд хүүхдийн асуудлыг хэвлэл мэдээлэлд тусгуулах, энэ асуудалд хэвлэл мэдээллийн үүрэг оролцоог дээшлүүлэхийн тулд эзэд, эрхлэгчдийн анхаарлыг татах, тэдэнд энэ асуудал чухал болохыг ойлгуулах, тэдний дэмжлэгийг авах явдал чухал юм. Энэ зорилгоор төвийн томоохон хэвлэл мэдээллийн байгууллагуудын удирдлагыг хамруулсан Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурах ёслолын ажиллагааг зохион байгуулсан.

Санамж бичгийн зорилго нь хэвлэл мэдээллийн нийтлэл, нэвтрүүлгийн бодлогод хүүхдийн асуудлыг тогтмол тусгах, телевиз радиогийн тодорхой цаг, сонины тодорхой булантай байх, хүүхдийн асуудалд ёс зүйтэй, хариуцлагатай ханддаг байх, мэргэшсэн сэтгүүлчидтэй болох зэрэг асуудалд эрхлэгч, эздийн анхаарлыг хандуулахад чиглэж байв. Харилцан ойлголцлын санамж бичгийн агуулгыг дараахь нийтлэг эрх ашигт тулгуурлан боловсруулж, зөвшилцсөн юм: Үүнд:

- Хүүхэд “мэдээллийн сэдэв”
- Хүүхэд “мэдээллийг бүтээгч”
- Хүүхэд “мэдээллийн хэрэглэгч”

Хүүхдийн асуудалд эдгээр гурван эрх ашгийг харгалзан мэргэжлийн түвшинд, ёс зүйтэй хандах нь чухал болохыг Санамж бичигт онцолсон юм.

Сайн туршлагыг хэрэгжүүлсэн үйл явц. Харилцан ойлголцлын санамж бичгийг 2009 оны 7 дугаар сарын 8-ны өдөр ОУХБ-ын АЙПЕК хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхдийн төлөө газар, Хэвлэлийн хүрээлэнгээс хамтран зохион байгуулсан. Энэхүү санамж бичгийг хүлээн зөвшөөрч гарын үсэг зурж, цаашид хүүхдэд ээлтэй сэтгүүл зүйг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулахаар томоохон 7 телевиз (МҮОНТ, ТВ9, Боловсрол суваг ТВ, Монгол ТВ, SBN телевиз, NTV телевиз, ТМ телевиз), 3 радио (МҮОНР, FM107.5 радио, FM104.5 радио), өдөр тутмын 6 сонин (Өнөөдөр, Өдрийн сонин, Зууны мэдээ, Нийслэл таймс, Нийгмийн толь, Үнэн) нэгдсэн бөгөөд эдгээр хэвлэл мэдээллийн байгууллагын шийдвэр гаргах түвшний удирдлагууд хүрэлцэн ирж, гарын үсгээ зурж баталгаажуулсан билээ. Уг ёслолын ажиллагаа нь хэвлэл мэдээллийн салбарт анхны тохиолдол бөгөөд хүүхдийн асуудалд хэвлэл мэдээллийн томоохон байгууллагын удирдлагууд дуу хоолойгоо нэгтгэн, ийнхүү анх удаа нийгмийн хөгжлийн асуудалд нэгэн зэрэг анхаарлаа хандуулсан чухал үйл явдал байлаа.

Ойлголцлын санамж бичигт нэгдэх үйл ажиллагааг зохион байгуулахын тулд томоохон хэвлэл мэдээллийн байгууллагуудад албан бичгээр хандаж, ганцаарчилсан болон хамтын урьдчилсан уулзалтуудыг хийсэн. Мөн “Хүүхдийн асуудал хэвлэл мэдээлэлд” сэдвээр Хэвлэлийн хүрээлэн албаны ёсны байр сууриа илэрхийлж, бүхий л хэвлэл мэдээллийн

хэрэгслээр сурталчилж хэвлэлийн бага хурал зохион байгуулав. Түүнчлэн санамж бичигт гарын үсэг зурах ёслолын ажиллагааны үеэр өсвөрийн сурвалжлагч хүүхдийн дуу хоолойг сонсож, өнөөдөр хэвлэл мэдээллээр тэд юу хүлээж авч байгаа, юу хүлээж авахыг хүсч байгаа талаарх санаа бодлыг нь сонссон.

Сайн туршлагыг хэрэгжүүлэх нөхцөл:

- Санаачлагч байгууллага нь шийдвэр гаргах түвшний удирдлагуудад нөлөөлөхүйц, бусдыг уриалах чадвартай байх
- Санамж бичгийн хэрэгжилтийг эргэж хянах, хэрэгжилтийг дэмжих асуудлаар холбогдох байгууллагууд хамтын ажиллагаагаа хөгжүүлэх

Сайн туршлагаас гарсан сургамж:

- Нийгмийн хөгжлийн асуудалд хэвлэл мэдээллийн үүрэг оролцоог дээшлүүлэхэд сэтгүүлчидтэй хамтран ажиллахаас гадна нийтлэлийн бодлогын түвшинд хамтрах хэрэгтэй.
- Нийтлэлийн бодлогыг тодорхойлохын тулд хэвлэл мэдээллийн агуулгын судалгааг нарийвчлан гүнзгийрүүлсэн түвшинд хийх, судалгааны дүнг практикт өргөнөөр ашиглах, сурталчлах, лоббидох шаардлагатай.
- Хүүхдийн дуу хоолойг хэвлэл мэдээллийн байгууллагуудын шийдвэр гаргагчдад хүргэх нь чухал.
- Санамж бичгийн хэрэгжилтийг дэмжих нэг чухал арга хэрэгсэл бол мониторинг юм. Иймд хүүхдийн асуудал хэвлэл мэдээлэлд хэр тусгагдаж, нэмэгдсэн талаар мониторингийг хоёр жил дараалан хийхээр холбогдох байгууллагуудтай тохиролцоод байна.

Сайн туршлагын талаар нэмэлт мэдээлэл өгөх хүн:

- Г. Гүнжидмаа, Хэвлэлийн хүрээлэнгийн Мэдээлэл судалгааны албаны дарга,
утас: 88008787, э-шуудан: gunjidmaag@yahoo.com

Хавсралт 5. Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн хохирогч хүүхдэд нийгэм, эрх зүйн үйлчилгээг хамтарсан багаар хүргэх

Байгууллагын нэр: Хүчирхийллийн эсрэг үндэсний төв


Үндэслэл. Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн хүүхэд сэтгэл санааны болон бие махбодийн хохирол эдлэхийн зэрэгцээ аюулгүй байдал нь алдагдаж, эрсдэлтэй нөхцөлд орсон байдаг. Хохирогч хүүхдийн онцлог хэрэгцээнд нийцсэн нөхөн сэргээх үйлчилгээ, дэмжлэгийг үр дүнтэй хүргээгүй цагт хүүхдийг дахин бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн эрсдэлд орохоос хамгаалж чадахгүй. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд цаашид бэлгийн мөлжлөгт орох эрсдэл нь бусад хүүхдээс илүү байдаг. Нэгэнт бэлгийн мөлжлөгт өртөөд хамгаалагдаагүй хүүхэд насанд хүрэхээрээ бусад хүүхдэд сөргөөр нөлөөлөх, эрсдэлтэй зан үйлтэй болох тохиолдол цөөнгүй. Тиймээс бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгийн хохирогч хүүхдэд цаг алдалгүй нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх нь нэн чухал.

Хохирогч хүүхдийг түүний эсрэг гэмт хэргийг хуулийн байгууллагаар шийдвэрлэхэд мэдүүлэг, нотолгоо гаргуулахад оролцуулахаас гадна тэднийг нөхөн сэргээх, хамгаалахад нэн тэргүүнд анхаарах ёстой. Хүүхдэд ямар үйлчилгээ тусламжийг хэрхэн үзүүлэх талаар эрх зүйн зохицуулалт дутмаг, хэрэгжүүлэх арга зүй тодорхой бус, хуулиар үүрэг хүлээсэн мэргэжилтнүүд хоорондоо холбогдож ажилладаггүй байдал үргэлжилсээр байна.

Иймээс бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн хохирогч хүүхдийг хамгаалах, эрхийг нь сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээг гол, гол салбарын мэргэжилтнүүд хугацаа алдалгүй, харилцан уялдаатайгаар үзүүлэх **хамтарсан багийн аргачлалыг** гэмт хэргийн хохирогч хүүхдийн бодит жишээн дээр тулгуурлан боловсруулах зорилготой төслийг Монголын хүүхдийн эрхийн үндэсний төв, Өсвөр үеийнхний хөгжлийн төв, Хүүхэд залуучуудын хөгжил, хамгаалал төв болон мэргэжлийн бусад байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтран хэрэгжүүлээ. Мөн бэлгийн мөлжлөг ба бэлгийн хүчирхийллийг хориглох, шийтгэх, хохирогч хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбогдсон хууль эрх зүйн орчин, практикт гарч буй сул тал хийгээд боломжуудад дүгнэлт хийж, зөвлөмж боловсруулсан юм.

Сайн туршлагыг хэрэгжүүлсэн үйл явц. ТББ-ууд хамтран ажиллахдаа өөр өөрсийн туршлага, арга барилаа нэгтгэх, боловсронгуй болгох, улмаар хууль хяналтын болон төрийн үйлчилгээний байгууллагын мэргэжилтнүүдийн үйл ажиллагаатай уялдуулах замаар, хүүхэд бүрийн онцлог хэрэгцээнд тулгуурлан хохирогч хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээхэд чиглэсэн нийгэм, эрх зүйн үйлчилгээг хамтарсан багаар зэрэгцүүлэн үзүүлсэн.

Хамтарсан баг



Хамтарсан баг дараахь дарааллаар хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлдэг:

- Кейс менежер (нийгмийн ажилтан), сэтгэл зүйч анх хохирогч хүүхэдтэй уулзаж хямралын байдлыг тогтооно.
- Кейс менежер, сэтгэл зүйч хүүхдийг тайвшруулан шаардлагатай үйлчилгээнд холбон зуучилна. Жишээ нь, яаралтай хуулийн үйлчилгээ шаардлагатай бол өмгөөлөгчтэй болоход тусална.
- Кейс менежер нөхцөл байдлын үнэлгээ хийж хүүхдийн эрсдлийг тогтооно. Үүний үндсэн дээр хамгаалах байранд оруулж, эрсдэлтэй орчноос тусгаарлах ба эрүүл мэндийн үзлэг, үйлчилгээнд хамруулна.
- Шаардлагатай тохиолдолд, өмгөөлөгч шүүх эмнэлгийн шинжээч тогтоох тухай тогтоол гаргуулна.
- Өмгөөлөгч хүүхдэд өргөдөл бичихэд нь тусална.
- Байцаан шийтгэх процесс, таслан шийтгэх үйл явцыг баримтжуулна.

Байцаан шийтгэх, яллагдагчийг таслан шийтгэх процесс дуустал хүүхдэд нийгмийн ажлын болон нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлсээр байдаг. Түүнчлэн хамтарсан багийн гишүүд тогтмол үүлзалдаж, ажлын явц, хүүхдэд гарч буй өөрчлөлт, цаашдын ажлын стратегия зөвшилцөж хэлэлцдэг.

Үр дүн:

- Хамтарсан баг хохирогч хүүхдийн хэрэгцээг зөв, бүрэн тодорхойлох аргачлалын эхний хувилбарыг боловсрууллаа. Хамтран ажиллах хугацаанд үйлчилгээ үзүүлэгч мэргэжилтнүүдийн үүрэг тодорхой болж, харилцан уялдаатай ажилласны үр дүнд шүүхийн шийдвэр болон цаашид хууль эрх зүй орчинг боловсронгуй болгоход нөлөөлөх боломж бүрдсэн.
- Хохирогч хүүхдэд нөхөн сэргээх цогц үйлчилгээнд хамрагдсанаар хэргийн талаар мэдүүлэхдээ айхгүй байх, аль болох илүү мэдээлэл өгч чадаж байгаа нь хэргийг хянан

шалгах ажилд эерэгээр нөлөөлж байна. Нөгөө талаар хохирлыг тогтооход ч хүүхдийн мэдүүлэг болон мэргэжилтнүүдийн дүгнэлт чухал үүрэг гүйцэтгэдэг болсон. Тиймээс мэргэжилтнүүд ч хамтран ажиллах сонирхол илүү болж байна.

Сайн туршлагыг хэрэгжүүлэх нөхцөл:

- Хамтран ажиллах эрмэлзэл: Хамтран ажилласнаар тухайн мэргэжилтний хүлээж буй үүргийн хэрэгжилт болон хохирогч хүүхдэд эерэг нөлөө үзүүлэх илүү боломжтойг ойлгуулах (Энэхүү арга зүйг хэрэгжүүлэхэд санхүүгийн боломжоос илүү сэтгэл санааны нэгдмэл байдал чухал)
- Хамтын ажиллагааны журам: Багийн гишүүдийг тодорхой болгож, хэн ямар үүрэг хүлээх, хэрхэн гүйцэтгэх талаар багийн дүрэм журмыг тогтоох нь чухал (Энэ журам нь заавал хуулинд заасан үүргээр хязгаарлагдах бус “хуулиар хориглоогүй бол зөвшөөрөгдөх” зарчмаар баталгаажих боломжтой).
- Туршлага, арга зүйн мэдлэг: Багийн гишүүн бүр хохирогч хүүхдийн онцлог хэрэгцээ, тэдэнд үйлчилгээг хэрхэн хүргэх талаар мэдлэгтэй байх нь чухал. Иймд багийн хамгийн эхний ажил дотоод сургалтаас эхлэх шаардлагатай юм.

Сайн туршлагаас гарсан сургамж:

- Хохирогч хүүхдийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд харгалзан үзэх, энэ чиглэлээр төрөөс шууд үзүүлэх санхүүгийн тусламж байхгүй тул төрийн бус байгууллагын нөөцийг ашигласан. Гэвч цаашид хамгаалах байр, нийгмийн үйлчилгээний зардлыг төрөөс санхүүжүүлэхэд анхаарах нь чухал.
- Багийн гишүүдийн хүлээх үүргийг илүү тодруулахын тулд ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээ болон байгууллагын дотоод журам, ажлын үнэлгээний үзүүлэлт зэрэгт тусгах хэрэгтэй.
- Багийн ахлагч чухал үүрэгтэй бөгөөд зохион байгуулалтаас бүх зүйл шалтгаалдаг гэдгийг анхаарах нь чухал.
- Баг хэт олон гишүүнтэй байх нь (5- аас дээш) бэрхшээл үүсгэдэг. Шаардлагатай тохиолдолд л өөр бусад мэргэжилтнүүдийг татан оролцуулж болно.
- Багийн гишүүдийг эд зүйл, мөнгөөр урамшуулахаас илүү харилцан мэдээлэл солилцох, хамтын ажиллагааны үр дүнд мэргэжил, туршлагын хувьд өсөн дэмжих боломж олгох, хохирогч хүүхдэд үзүүлж буй дэмжлэг туслалцааны үр дүнгээр урамшуулах нь оновчтой.
- Багийн гишүүдийг харъяалдаг байгууллага, салбарын удирдах албан тушаалтанд багийн ач холбогдол болон гишүүдийн гүйцэтгэх үүргийн талаар мэдээлэл өгөх, удирдлагын хувьд хүлээх үүргийг тодруулах нь багийн гишүүдийн идэвхид нөлөөлдөг.
- Багийн ажлын үр дүнг олон хэлбэрээр танилцуулах, зохион байгуулах нь нөлөөллийн болон гишүүдийг урамшуулах, идэвхжүүлэх олон талын ач холбогдолтой.
- Хохирогчийг зөвхөн шууд хохирсон хүүхдээр хязгаарлах бус гэр бүлийн гишүүдийг хамруулж, тэдэнд давхар үйлчилгээ үзүүлэх шаардлагатай нь харагдсан.

Сайн туршлагын талаар нэмэлт мэдээлэл өгөх хүмүүс:

- Б. Арвинтариа, ХЭҮТ-ийн Хуулийн хөтөлбөрийн зохицуулагч, утас 99204558, э-шуудан: arvin_taria@yahoo.com
- Д. Саруул, ХЭҮТ-ийн хуульч, утас: 88769105, э-шуудан: dsaruul999@yahoo.com

Хавсралт 6. Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн охидод сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх

Байгууллагын нэр: Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газар

Үндэслэл. Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн хохирогч хүүхэд, түүний гэр бүл хаана, хэнд хандахаа мэдэхгүйгээс эрхээ хамгаалуулж, сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдаж чаддаггүй байсан. Хүүхдийг илрүүлэх, нөхөн сэргээх, тэдний эрхийг хамгаалах үйлчилгээг хөгжүүлэх шаардлагатай байлаа. Тиймээс бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн хүүхдийн эрхийг хуулийн хүрээнд хамгаалах, хүүхэд болон тэдний гэр бүлд сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх зорилгоор аймгийн Хүүхдийн төлөө хэлтсийн дэргэд “Охидын соёл хөгжлийн төв”-ийг байгуулж ажиллуулав.

Сайн туршлагыг хэрэгжүүлсэн явц. Дараахь арга хэмжээг хэрэгжүүллээ. Үүнд:

- “Охидын соёл хөгжлийн төв”-ийг аймгийн Хүүхдийн төлөө хэлтсийн дэргэд тусгай өрөө гарган байгуулж, сэтгэл зүйч ажиллуулах болсон. Эхний үед сэтгэл зүйчийн цалинг АЙПЕК хөтөлбөрөөс санхүүжүүлж байв. Улмаар төвийн ач холбогдлыг шийдвэр гаргагчдад ойлгуулснаар байнгын орон тоо болгон өргөтгөж, цалинг нь төсөвт суулгаж чадсан.
- Дараа нь хүүхдийн асуудлаар ажилладаг ажилтнууд, шүүгч, цагдаа, прокурор, өмгөөлөгчдийг энэ асуудлаарх ойлголт, чадавхийг нь дээшлүүлэх сургалт зохион байгуулж, уг сургалтанд Улаанбаатарт энэ чиглэлээр мэргэшин ажилладаг төрийн бус байгууллагын мэргэжилтэнг урьж ирүүлэн, хүүхдийн бэлгийн мөлжлөгийн хохирогчийг илрүүлэх, тэдний эрхийг хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх арга ажиллагаанд суралцсан.
- Бэлгийн мөлжлөгт өртсөн болон эрсдэлтэй хүүхдүүдийг илрүүлэхийн тулд зочид буудал, шөнийн цэнгээний газар, үйлчилгээний байгууллагуудад гэнэтийн шалгалт хийж байсан. Гэтэл эдгээр байгууллагуудын ажилтнуудтай хамтран ажиллах шаардлагатай аяндаа тулгарсан юм. Тиймээс үйлчилгээний байгууллагын менежментийн сургалтад эдгээр байгууллагуудын удирдлагуудыг урихад тэд нэн талархалтайгаар оролцсон бөгөөд энэ сургалтын явцад тэдэнтэй хамтран ажиллах чиглэлээ тодорхойлон ажиллаж байна.
- Мөн аймгийн төвийн Хэрлэн сумын багуудад тухайн багийн Засаг дарга, багийн болон сургуулийн нийгмийн ажилтан, хэсгийн байцаагч, өрхийн эмч, хэсгийн дарга, СӨХ-ийн дарга нараас бүрдсэн “хамтарсан баг”-ийг байгуулав. Хамтарсан баг нь бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгт өртсөн болон өртөх эрсдэлтэй охидыг илрүүлж, энэ талаарх мэдээллийг Охидын соёл хөгжлийн төв, Цагдаагийн газарт мэдээлэх ба “хамтарсан баг” хохирогчийг хамгаалалтандаа авна.
- Хүүхдийн бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгийн талаарх олон нийтийн ойлголт хандлагыг дээшлүүлэх зорилгоор хуулийн болон ёс суртахууны холбогдолтой мэдээллийг сургалт, хэвлэмэл материал болон мэдээллийн хэрэгслээр хүргэж байлаа.
- Түүнчлэн Хилийн цэргийн шалган нэвтрүүлэх ангитай хамтран хилээр ажил эрхлэх зорилгоор орж ирж байгаа гадаадын иргэдийн паспортын завсар хятад хэл дээр бичсэн санамж бичгийг хавчуулж, мэдээлэл өгч байсан.

- Хүүхдийн бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг нь гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэл учраас Цагдаагийн газартай харилцан мэдээлэл солилцож, нягт хамтран ажиллаж байв.

Хамтарсан баг хохирогч хүүхдэд дараахь үйлчилгээ үзүүлдэг:

1. Хохирогчийг аюултай орчноос тусгаарлаж, төрөл садангийнх нь түр хамгаалалтанд өгсний дараа сэтгэл зүйн зөвлөгөөг үе шаттайгаар өгөх
2. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтанд оролцох, өмгөөлөгчтэй холбох
3. Хүүхдийн хэрэгцээг тодорхойлох, гэр бүлийг судалж, зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах
4. Хүүхдийг нийгэмшүүлэх, нөхөн сэргээх үйлчилгээ, хөгжүүлэх болон амьдрах ухааны сургалтуудад хамруулах

Үр дүн:

- Охидоос мэдүүлэг авах ажиллагаанд Хүүхдийн төлөө хэлтсийн ажилтан оролцох болсоноор мэдүүлгийн үед гарч байсан хүндрэлүүд багасч, охидын эрх нь хамгаалагдах болсон.
- Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарын ойлголт хандлага өөрчлөгдөж, харилцаа сайжирснаар хүчирхийлэл үйлдэгч болон тэдний хамаатан садны дарамтыг даван туулахад охидод сайн дэмжлэг болсон.
- Хуулийн байгууллага, хүүхдийн байгууллагын хамтын ажиллагаа сайжирсан, тухайлбал прокурор, шүүхийн шатанд хүүхдийн байгууллага оролцож хөндлөнгийн ажиглалт хийх, тайлбар, нэхэмжлэл гаргах, хүүхдийн эрхийг хамгаалах боломжтой болсон.

Сайн туршлагыг хэрэгжүүлэх нөхцөл:

- Мэргэжлийн сэтгэл зүйч ажиллах
- Холбогдох байгууллагуудын хамтын ажиллагаа бэхжиж, ойлголт хандлага өөрчлөгдөн, энэ чиглэлээр ажиллах чадавхи сайжирсан байх
- Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх болон бэлгийн мөлжлөгт өртсөн охидоос мэдүүлэг авах таатай орчинг бүрдүүлсэн байх
- Хуулийн байгууллага, хүүхдийн байгууллага хоорондоо мэдээлэл солилцдог байх.

Сайн туршлагаас гарсан сургамж:

- Бэлгийн хүчирхийлэлд өртсөн охидын анхны мэдүүлгийг бичлэг хийж баримтжуулах шаардлагатай. Ингэснээр хүүхдийг олон дахин байцааж, түүнд учирсан сэтгэлийн хямрал сэдэрэхээс урьдчилан сэргийлэх ёстой.
- Өмгөөлөгчийг сонгохдоо анхаарах хэрэгтэй. Жишээ нь: хохирогчийн өмгөөлөгч, хүчирхийлэгчийн өмгөөлөгч хоёр хамаатан садан байж болзошгүй.
- Шаардлагатай гэж үзвэл хохирогч хүүхдийг шүүх хуралд оролцуулахгүй байхад анхаарах хэрэгтэй.
- Хохирогч хүүхдийг аюултай орчноос нэн даруй тусгаарлах хэрэгтэй. Мөн нууцыг маш сайн хадгалах нь чухал.

Сайн туршлагын талаар нэмэлт мэдээлэл өгөх хүмүүс:

1. А. Нансалмаа, Хүүхдийн төлөө хэлтсийн дарга, утас: 99037701, 93065858, э-шуудан nansalmaa_a@yahoo.com
2. Т. Шинэцэцэг, Хүүхдийн төлөө хэлтсийн сэтгэл зүйч, утас: 99055776, 93065855, э-шуудан tshinetsetseg@yahoo.com

Хавсралт 7. Тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрөөс хөндийрсэн хүүхдийн сурах боломжийг хангах

Байгууллагын нэр: Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газар

Үндэслэл. Дорноговь аймгийн Айраг сумын нутагт жоншны албан бус уурхай олон бий. Сумын төвд байдаг тааруу амьдралтай айлын хүүхдүүд хичээлээ таслан, зарим нь сургуулиас завсардан эцэг, эх, хамаатан саднаа даган жоншин дээр ажиллах хандлага элбэг. Тэдгээр хүүхдийг хөдөлмөрөөс нь хөндийрүүлэх, нөхөн сэргээх олон төрлийн арга хэмжээ авч байна. Тэдгээрийн нэг нь тэвчишгүй хөдөлмөр эрхэлдэг, эрх нь зөрчигдсөн хүүхдийг эргүүлэн сургуульд нь сургах, сургуулиас нь завсардуулахгүй байх нөхцлийг хангах зорилгоор сумын төвд гэртээ амьдардаг боловч амьдралын боломжгүй, эсвэл хүнд нөхцөлд байгаа сурагчдыг сургуулийн дотуур байранд суулгаж, амьдарч сурах таатай нөхцөл боломжоор хангаж байна. Мөн гэртээ амьдардаг боловч амьдралын боломж муутай, хоол хүнсний дутагдалтай зарим хүүхдийг дотуур байрандаа хооллож байна. Эдгээр арга хэмжээ нь хүүхдийг хөдөлмөрөөс хөндийрүүлэх, урьдчилан сэргийлэхэд мэдэгдэхүйц ач холбогдолтой байлаа.

Сайн туршлагыг хэрэгжүүлсэн үйл явц. Төслийн үйл ажиллагаа эхлэх үед Аймгийн болон сумын ажлын хэсэг Айраг сумын “Цагаан дэл” албан бус жоншны уурхайд олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэж байгаа хүүхдийг олж илрүүлэх үйл ажиллагаа зохион байгуулсан юм. Энэ үед нэлээд хэдэн хүүхэд сургуулиас завсардан, эсвэл хичээлээ таслан ажилладаг болох нь тодорхой болсон. Тэдгээр хүүхдийг албан бус сургалтад сургах, хичээлийнх нь ирцэд хяналт тавих зэргээр ажилласан байсан боловч бүгдийг нь уурхайн хөдөлмөрөөс бүрэн хөндийрүүлж чадахгүй байв. Хичээлийн завсар чөлөөгөөр уурхайд ажиллаж байгаа хүүхдийн ар гэрийн нөхцөл байдал нь туйлын хүнд тул хүүхдүүд хоногийн хоолоо залгуулахын тулд ажиллаж байжээ. Тиймээс хүүхдүүдийн сурах боломжийг нь хангаж өгөх шаардлагатай болсон юм.

Хүүхдүүдийн эцэг эхтэй нь нэг бүрчлэн уулзаж, зарим хүүхдийг сургуулийн дотуур байранд суулгах, зарим хүүхдийг байранд суулгахгүйгээр байрны хоолонд оруулж байх талаар тохиролцсон. Зарим эцэг эх эхэндээ дургүй байсан ч одоо энэ арга хэмжээг дэмждэг болсон юм. Гэр нь сумын төв дээр байдаг нийт 16 хүүхдийг дотуур байранд авч, таван хүүхдийг дотуур байранд хооллох болсон. Айраг сумын дотуур байрны хүрэлцээ тийм ө хангалттай биш боловч ямар ч л байсан батлагдсан төсөвтөө багтаагаад ийнхүү хүнд нөхцөлд байгаа хүүхдэд боломж олгох алхам хийлээ. Тэдгээр хүүхдийн гурав нь сургууль завсардсан, бусад нь хичээлдээ тэр бүр явдаггүй хүүхэд байсан юм. Сургууль завсардсан гурван хүүхэд нь албан бус боловсролын сургалтаар хичээлээ нөхөөд одоо өдрийн ангидаа суралцаж байна. Эдгээр хүүхдийг төсөлд хамруулахдаа хичээлийн хэрэгсэл, дүрэмт хувцсаар хангасан. Зарим нэг эцэг эхийг байнгын болон түр ажлын байранд зуучилсан. Өөр тусламж дэмжлэг үзүүлдэг байгууллагуудад хандаж арван хүүхдийн гэр бүлд хоол хүнс, хувцас, эд барааны дэмжлэг үзүүлээд байна.

Үр дүн:

- Хүүхдүүд дахин жоншны уурхай явахаа больж, өөртөө итгэлтэй болж, хичээлдээ шамдан суралцах болсон. Нэг хүүхэд урлагаар, өөр нэг хүүхэд чөлөөт бөхөөр улсын хэмжээнд амжилт үзүүлээд байна.
- Нутгийн иргэд хүүхдийн хөдөлмөрийн талаар зохих ойлголттой болж, сумын төвд гэртэй боловч зайлшгүй амьдралын шаардлагатай өрхийн хүүхдүүдийг сумын

дотуур байранд суулгах нь зөв гэсэн хандлага бий болж байна.

Сайн туршлагыг хэрэгжүүлэх нөхцөл:

- Сургуулийн дотуур байрны зардлыг урьдчилан төлөвлөж, хүрэлцэхүйц хэмжээгээр төсөвлөсөн байх.
- Тэдгээр хүүхдийн дотуур байранд суух зайлшгүй шаардлагын талаар олон нийтэд зөвөөр ойлгуулсан байх.
- Дотуур байрны багшийг хүүхдийн хөдөлмөрийн талаар ойлголттой болгож, тэдэнтэй тусгайлан ажиллах арга барилд сургах.
- Сургуулийн захирал, нийгмийн ажилтан, их эмч, сургуулийн дотуур байрны багш нар хамтран ажиллах.

Сайн туршлагаас гарсан сургамж:

- Эцэг эхтэй уулзаж, тэднийг хүүхдийн хөдөлмөр болон хүүхдийг нь дотуур байранд байлгах талаар сайтар зөвлөлдөх шаардлагатай.
- Эцэг эхтэй нь анги удирсан багшаар дамжуулан байнгын холбоотой ажиллах, ахуй амьдралыг дээшлүүлэх арга хэмжээ авах шаардлагатай.
- Аймгийн Боловсрол, соёлын газарт хүүхдүүдийн нөхцөл байдлыг тайлбарлан ойлгуулах нь зүйтэй. Хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийг устгахад боловсролын үйлчилгээний гүйцэтгэх үүргийг бодитой хэрэгжүүлэхэд харилцан ойлголцол, хамтын ажиллагаа чухал.
- Өөр олон хүүхэд дотуур байранд суух хүсэлт гаргах, дотуур байранд суух ёстой хүүхдийн эцэг эхээс гомдол гаргахаас урьдчилан сэргийлж олон нийтэд зөв тайлбарлан ойлгуулах нь зүйтэй.

Сайн туршлагын талаар нэмэлт мэдээлэл өгөх хүмүүс:

- С.Зоригт-Эрдэнэ, Айраг сумын сургуулийн захирал, утас 93051151,
- Н.Гантуяа, Айраг сумын ЗДТГ-ын нийгмийн хөгжлийн бодлого хариуцсан мэргэжилтэн, утас 93051173,
- Б.Туулайхүү, Айраг сумын сургуулийн нийгмийн ажилтан, утас 93084189, э- шуудан ok_tuulai@yahoo.com

Хавсралт 8. Боловсролын хувилбарт хөтөлбөрийг таниулсан туршлага

Байгууллагын нэр: Гэр бүлийн хөгжлийн төв

Үндэслэл. ОУХБ-ын АЙПЕК хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр хөдөлмөр эрхэлдэг хүүхдийн бага насны дүү нарыг сургуулийн өмнөх боловсролд (СӨБ) нэг жилийн хугацаатайгаар хамруулж, сургуульд орох бэлтгэлийг хангах, улмаар хүүхдийг хамрах тойргийн сургуульд оруулах зорилгоор “Янзагахан” цэцэрлэгийг байгуулан, “Эрдмийн алтан хаалга” сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалтын иж бүрдэл гарын авлагыг боловсруулж, сургалтандаа ашиглаж эхэлсэн юм. Уг гарын авлагыг ашиглахтай холбогдсон зөвшөөрлийг БСШУЯ болон эрх бүхий холбогдох бусад байгууллага өгсөн болно.

Сайн туршлагыг хэрэгжүүлсэн үйл явц. “Эрдмийн Алтан хаалга”-ыг төслийн энэ шатанд улам боловсронгуй болгож, сургалтын хөтөлбөр, гарын авлагын багц хэрэглэгдэхүүнийг өргөн хүрээнд сурталчлах, түгээх ажлыг зохион байгуулав. Үүнд:

- Сургалтын хөтөлбөр, багц хэрэглэгдэхүүний талаар нийслэлийн 50 цэцэрлэгийн багш, ажилтнуудад сургалт явуулж, туршлагаа хуваалцсаны үр дүнд бусад цэцэрлэгийн багш нар энэ хөтөлбөрийг ихээхэн сайшаан, долоо хоногийн амралтын өдрүүдэд явуулдаг СӨБ-ын хувилбарт сургалтын хэлбэрийг нэвтрүүлэх сонирхол нь нэмэгдэж байна.
- Уг хөтөлбөр дээр суурилсан 17 цуврал хичээлийг Боловсрол Суваг ТВ-тэй хамтран бэлтгэж, орон даяар нэвтрүүлээ. Боловсрол сувгийн нэвтрүүлэг бүх аймаг, суманд гардаг тул олон хүн, ялангуяа СӨБ-ын багш, эцэг эхчүүдэд хүргэх боломжтой суваг юм.
- Хот, хөдөөгийн цэцэрлэгийн багш, мэргэжилтнүүд сургалтын хөтөлбөр, багц хэрэгдэгдэхүүний талаар мэдээлэл авах, ашиглах явдлыг дэмжих зорилгоор тэдгээрийг өөрийн байгууллагын веб хуудсанд байршуулж, зайны сургалтаар түгээхийг чармайж байна. Онлайнаар бүртгүүлсэн сонирхогч багш, эцэг эхчүүд уг сургалтын гарын авлагыг ашиглан илүү олон хүүхдэд СӨБ олгох боломжтой. Гэр бүл хөгжлийн төвийн galaxy-edu.org веб хуудсанд бүртгүүлж, арга зүйн дэмжлэг авах бүрэн боломжтой.

Үр дүн:

- Эцэг эхчүүдийн хандлага өөрчлөгдөж, өөрсдөө хүүхдээ авчирч сургалтад хамруулах сонирхолтой болсон.
- Судалгааны дүнгээс харахад “Янзагахан” цэцэрлэгээс ЕБС рүү шилжүүлсэн хүүхдүүдээс сургуулиас завсардсан хүүхэд байхгүй байна.
- “Эрдмийн алтан хаалга” иж бүрдэл номын эрэлт хэрэгцээ өссөн.

Сайн туршлагыг хэрэгжүүлэх нөхцөл:

- “Эрдмийн алтан хаалга” сургалтын иж бүрдэл нь СӨБ-ыг хөдөө орон нутаг, алслагдмал газарт, эцэг эхчүүд гэртээ хүүхэддээ эзэмшүүлэх боломж олгодог. Тиймээс сургалтын гарын авлага, зөвлөмж, хөтөлбөртэй багш нь сайтар танилцсан байх хэрэгтэй.

- Сургуулийн өмнөх боловсролын тухай хуультай сайтар танилцаж, хувилбарт сургалтыг төрөөс санхүүжүүлэх тухай заалтыг ашиглах боломжтой.

Сайн туршлагаас гарсан сургамж:

- “Эрдмийн алтан хаалга” сургалтын иж бүрдлийг зааж сургасны дараа хүүхдийн мэдлэгийн түвшинд мониторинг хийх хэрэгтэй.
- Бямба, Ням гаригийн хувилбарт сургалтын үр дүн энгийн цэцэрлэгийн сургалтын үр дүнтэй бүрэн дүйж байгаа төдийгүй, энгийн цэцэрлэгийн анги танхимыг ашиглан явуулах боломжтой учраас цаг, зардал хэмнэж, олон хүүхдийг цэцэрлэгт хамруулах боломжтой нь батлагдсан.

Сайн туршлагын талаар нэмэлт мэдээлэл өгөх хүн:

- Г. Даваахүү, ГБХТ ТББ-ын тэргүүн, утас 91916494, э-шуудан galaxy_mgl2005@yahoo.com

Хавсралт 9. Урлаг, бүтээлч үйл ажиллагаагаар дамжуулан хүүхдийг нийгэмшүүлэх, хөгжүүлэх нь

Байгууллагын нэр: Тэгш мөр төв ТББ

Үндэслэл. Хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд аюул ихтэй, эрсдэлтэй нөхцөлд ажиллахаас гадна хүүхэд байх эрхээ эдэлж чадахгүй, өөрийнхөөрөө байх, чөлөөтэй тоглож наадах, өөрийн сонирхдог зүйлээрээ хичээллэх боломжгүй байдаг. Олон хүүхэд гэр бүл, үе тэнгийнхэн, томчуулын хүчирхийлэл, ажил, амьдралын дарамтаас болж стресс-д орсон байдаг. Эдгээр нь хүүхэд амжилттай суралцахад саад учруулдаг. Хөдөлмөр эрхэлдэг хүүхдэд боловсрол, мэргэжил олгох, хоол хүнс, дүрэмт хувцас, хичээлийн хэрэгслийн дэмжлэг үзүүлэхээс гадна тэдэнд хүүхдээрээ байх, дуртай сонирхдог зүйлээ хийж, тоглож наадах, дуулж, зурж, бүжиглэх, найз нөхөдтэй байх, шинэ зүйлд суралцах боломжийг нэн тэргүүнд бүрдүүлэх нь чухал болохыг бидний туршлага харуулсан юм. Учир нь хүүхдүүд сэтгэл санааны хувьд тайвшрах, ямар нэг зүйлийг хийж бүтээж чадна гэдэгтээ итгэлтэй болох, найз нөхөдтэй болж шинэ орчинд дассанаар илүү богино хугацаанд нийгмийн амьдралд буцаж орох, нийгэмших, өөрийгөө шинэ алхамуудад сорих чадвартай болдог. Мөн урлаг, бүтээлч үйл ажиллагаа нь хүүхдийн нөхцөл байдалд бодитой үнэлгээ өгөхөд ач холбогдолтой. Урлаг, бүтээлч үйл ажиллагаа нь хүүхдэд төрөл бүрийн чиглэлийн ойлголт, мэдлэг өгөхөөс гадна, амьдрах ухаанд сургах, өөртөө итгэлтэй болох, сэтгэн бодох чадварыг нэмэгдүүлэх, бусадтай харилцах, аливаа үйл ажиллагаанд өөрийн хувь нэмрээ оруулах урам өгдөг.

Сайн туршлагыг хэрэгжүүлсэн үйл явц. Хүүхдүүдийг урлаг, бүтээлч үйл ажиллагаагаар дамжуулан нийгэмшүүлэхдээ урлагийн дараахь төрлийг ашигласан юм. Үүнд:

- Фото зураг авах
- Цаас болон хаягдал материалаар наамал /мозайк/ хийх
- Бүжиглэх
- Шүлэг зохиох
- Сэтгэгдлээ илэрхийлэх
- Уран зураг зурах

Дээрх урлагийн хэлбэрүүд нь хүүхдийг ямар нэгэн фото зурагчин, эсвэл бүжигчин болгохдоо бус зөв төлөвшилтэй болгох, урлагаар дамжуулж үзэл бодлоо илэрхийлэх, сэтгэн бодох чадварт сургах, өмнөө зорилго тавьж түүндээ хүрэхийн төлөө тэмүүлэх, хүсэл мөрөөдөлтэй болгоход чиглэгдэнэ.

“Фото зураг”: Энэхүү төсөл нь “Миний нүдээр миний ажлын байр”, “Миний хүсч буй ирээдүй” гэсэн хоёр үе шаттайгаар хэрэгжсэн ба хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд өөрсдийн ажлын орчин нөхцөл, амьдралын хүнд нөхцөл болон баяр баясалтай мөчүүд, хүсч мөрөөддөг зүйлээ фото зурагт буулган томчуудад өөрсдийн бодит нөхцөл байдлыг харуулах, өөрсдийн бодол санаагаа илэрхийлэх зорилготой байлаа. Төслийн хүрээнд хүүхдүүд авсан зургаараа үзэсгэлэн зохион байгуулж олон нийтэд сонирхуулсан нь хүүхдийн хөдөлмөрийн талаар томчуудын ойлголтыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ фото аппараттай харьцах, фото зураг авч сурах, авсан зургаа шинжих зэрэг олон шинэ зүйл сурлаа.

“Урлаг амьдрал”: Гарын доорхи, олдоц элбэгтэй хаягдал түүхий эд, материалаар төрөл бүрийн гар урлалын зүйл, наамал эвлүүлэг /мозайк/ хийх нь хүүхдүүдэд сэтгэн бодох, тэсвэр тэвчээр шаарддаг урлагийн төрөл учраас энэ зан чанарыг төлөвшүүлэхээс гадна багаар ажиллах чадварт сургах, цаашид аливаа зүйлд суралцах сонирхлыг нэмэгдүүлэхэд үр дүнгээ өгсөн. Хүүхдүүд хийсэн бүтээлээ харж бахархах, цаашид олон зүйлийг хийж чадна гэсэн итгэл үнэмшилтэй болоход энэ төсөл илүү ач холбогдолтой байлаа. Энэхүү сургалтын сургагч багшаар Их Британийн “Аклам Гранж” сургуулийн багш Жаки Ричардсон ажилласан нь байгууллагын ажилтнуудын чадавхийг ч дээшлүүлэхэд их хувь нэмэр оруулсан.

Бүжгийн хичээл: Хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн чөлөөт цагийн Цоглог клуб болон Цоглог зуны зусланд бүжгийн хичээлийг зохион байгуулдаг. Бүжгийн хичээл нь 7 хоногт хоёр цагаар гурван удаа хичээллэдэг ба монгол бүжиг, танго, ча ча, самбо, вальс, аэробик зэрэг бүжгийн төрлүүд заадаг. Бүжиг нь хүүхдийн биеэ авч явах байдал, зөв сайхан хувцаслах, урлаг, уран сайхны мэдрэмжийг олох, өөрийн сэтгэлдээ тээж буй стрессээ тайлж, шинэ сайхан орчныг өөртөө бий болгоход ач холбогдолтой байлаа.

Шүлэг: Төсөлд хамрагдсан хүүхдүүдийн дунд шүлэг, яруу найраг бичих сонирхолтой хүүхэд олон байдаг. Цоглог клуб үйл ажиллагааныхаа хүрээнд хүүхдүүдийн дунд шүлгийн уралдаан зохион байгуулсан. Хүүхдүүд шүлэгтээ хөдөлмөр эрхэлсэн хүүхдийн амьдрал болон өөрт тохиолдсон гуниг зовлонгоо уран яруугаар дүрслэн харуулж байсан нь хүүхдүүд сэтгэлдээ ямар их зүйл тээж явдгийг илтгэсэн ба түүнийгээ илэрхийлэх хэрэгцээ шаардлага байдгийг харуулсан.

Уран зураг: Хүүхэд бүр зургийн авъяастай, тэдний зурсан зургийг муу, сайн гэж шүүх нь чухал биш юм. Тэд зурсан зургаараа бодол санаа, өөрт төрсөн сэтгэгдэл, сэтгэлийн баяр жаргалтай мөчүүд болон гунигтай байсан үеэ дүрслэн харуулдаг. Хүүхдүүдээр зураг зуруулахдаа ямар ч сэдэв өгч болдог. Хүүхэд сэдвийн хүрээнд зураг зурахын тулд эрэл хайгуул хийж, тухайн сэдвийн талаарх мэдлэгээ нэмэгдүүлж, баяжуулж байдаг. Уран зургийн хичээлийн хүрээнд хүүхдүүдэд чөлөөт сэдэв санал болгоход байгаль орчин, усны хомсдол, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн хөдөлмөр зэрэг хурц асуудлын тухай зурсан нь томчуудын адил эдгээр асуудалд санаа зовдог, мөн өөрийн амьдралын орчин тойронд тэдний сэтгэлийг эмзэглүүлдэг, хар бараан зүйлс олон байгааг илтгэн харуулж байлаа.

Үр дүн: Урлаг, бүтээлч үйл ажиллагааны үр дүн зөвхөн төсөлд хамрагдсан хүүхдүүд төдийгүй хэрэгжүүлэгч байгууллагын чадавхийг хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн.

Байгууллагын чадавхи, олон нийтэд үзүүлсэн үр дүн:

- Нийгмийн ажилтан болон багш нар хүүхдүүдтэй харилцах шинэ арга барилд суралцаж, хүүхдүүдийн талаар илүү их мэдээлэлтэй болсон ба шалгалтын бус хэлбэрээр хүүхдийг үнэлэх, дүгнэх чадвартай болсон.
- Хүүхдүүд болон багш, нийгмийн ажилтнуудын хооронд илүү сайн харилцаа, ойлголцол бий болсон.
- Хүүхдүүдийн бүтээлийг үзсэн эцэг эх, үе тэнгийхэн, олон нийтийн хандлагыг өөрчлөхөд эерэгээр нөлөөлсөн. Жишээ нь, хүүхдүүдийн авсан фото зургийн үзэсгэлэнг үзсэн хүмүүс хүүхдийн хөдөлмөрийн бодит нөхцөл байдал, хор уршгийн талаар зохих ойлголт, мэдлэгтэй болсон.

Хүүхдэд үзүүлсэн үр дүн:

- Өөртөө итгэлтэй, өөрийнхөө дуу хоолойг чөлөөтэй илэрхийлдэг болж, өөрийн чадвараа нээж чаддаг болсон.

- Архи хэрэглэх, тамхи татах нь багассан.
- Өөрийгөө илүү үнэлдэг болж, чөлөөт цагаа зөв, хөгжилтэй өнгөрөөдөг болсон.
- Суралцах чадвар нь дээшилсэн. Өмнөө зорилго тавьж, түүндээ хүрэхийн хичээл зүтгэл гаргадаг болсон. Ирээдүй болон хүсэл мөрөөдлийнхөө талаар боддог болсон.

Сайн туршлагыг хэрэгжүүлэх нөхцөл:

- Хүүхдүүдийн сонирхлыг судлах нь хамгийн чухал. Учир нь урлаг болон бүтээлч үйл ажиллагаа нь маш олон төрөл хэлбэрээр хэрэгжүүлэх боломжтой бөгөөд тухайн төрөл, хэлбэрүүдээс хүүхдийнхээ сонирхол, хэрэгцээнд тохирсон арга хэлбэрийг сонгох нь илүү үр дүнтэй. Урлагийн аль нэг төрлийг сонирхдоггүй, ямар нэг бүтээлч зүйл хийх сонирхолгүй хүүхэд гэж байдаггүй.
- Энэхүү туршлагыг ямар ч нөхцөлд хэрэгжүүлэх боломжтой ба хүүхэдтэй ажиллаж буй ажилтан нь урлагийн мэдрэмжтэй, хүүхэдтэй ажиллах хүсэл сонирхолтой, шинийг санаачлах, бүтээлч сэтгэлгээтэй байх нь ихээхэн үүрэгтэй. Мөн ямар ч нөхцөлд, ямар ч насны хүүхэдтэй хэрэгжүүлэх бүрэн боломжтой. Учир нь энэ туршлагыг хэрэгжүүлэхэд тухайн хүүхдийн бичиг үсгийн боловсрол, мэдлэгийн түвшин үл хамаарна.

Сайн туршлагаас гарсан сургамж:

- Хүүхдэд өөрсдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх орчин бүрдүүлж өгөх нь чухал. Тэд тухайн орчинд аюулгүй гэдгээ мэдрэх, мөн хэн нэгнээр буруу эсвэл зөв ярьж байгаагаа хянуулахгүй, нэг үгээр хэлбэл эрх чөлөөг мэдрэх хэрэгтэй.
- Сурган хүмүүжүүлэгч багш, нийгмийн ажилтан нар нь урлагийн талаар мэдлэгтэй, авъяастай байх нь чухал ч хамгийн гол нь тэд өсвөр насны хүүхдүүдтэй ажиллах чадвартай байх ёстой.
- Урлаг ба бүтээлч үйл ажиллагаа нь зөвхөн нэг хоёр удаагийн арга хэмжээ биш аль болох олон төрлөөр, олон давтамжтай байх хэрэгтэй.

Сайн туршлагын талаар нэмэлт мэдээлэл өгөх хүмүүс:

- П. Алгирмаа, утас: 88006346 , э-шуудан: algirmaa@cyppd.org
- Ж. Азжаргал, утас: 96630349, э-шуудан: azaa@cyppd.org

Хавсралт 10. Алтны албан бус уурхайд хүүхдийн хөдөлмөрийг устгахад сайн дурын идэвхтнүүдийн оролцоог дайчлах нь

Байгууллагын нэр: Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар

Үндэслэл: Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах аймгийн дэд хөтөлбөр боловсруулан, улмаар ОУХБ/АЙПЕК хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх явцад алтны албан бус уурхайд ажиллаж байгаа хүүхдүүдэд боловсролын үйлчилгээ үзүүлэх зорилгоор албан бус боловсролын гэр сургууль ажиллууллаа. Гэтэл алтны уурхайд ажиллаж байгаа хүмүүст хүүхдийн хөдөлмөрийн талаар шинэ ойлголт өгч хандлагыг өөрчлөн, тэдний хүчийг дайчлахгүйгээр хүүхдийг уурхайн хүнд, аюултай хөдөлмөрөөс хөндийрүүлэх боломжгүй гэдэг нь үйл ажиллагааны явцад тодорхой болсон юм. Энэ чиглэлээр хэрхэн ажиллаж болохыг Баян-Овоо сумын “Алтан ус” гэдэг газарт гар аргаар алт олборлогч болон тэнд үйлчилгээ эрхэлж байгаа иргэдтэй хамтран, тэдний хүчийг авч ажилласан туршлага харууллаа.

Сайн туршлагыг хэрэгжүүлсэн үйл явц: Гар аргаар алт олборлож байгаа уурхайд, газар, газрын олон янзын хүмүүс цугларсан байдаг боловч тэдэнд нийгмийн ямар нэгэн үйлчилгээ хүрээгүй хэвээр байна. Тэнд ажиллаж байгаа хүмүүс нь нутаг ус, танил талаараа хэд хэдэн бүлэгт хуваагдсан байдалтай, ямар нэгэн нэгдсэн зохион байгуулалтгүй амьдардаг. Хүмүүс нь ерөнхийдөө хоёр бүлэгт хуваагдана. Нэг хэсэг нь гар аргаар алт олборлогчид, нөгөө хэсэг нь тэдэнд зориулан жижиг худалдаа, гуанз ажиллуулдаг, алт худалдан авдаг хүмүүс юм.

Хүүхдүүдийг уурхай дахь хөдөлмөрөөс нь хөндийрүүлэхийн тулд эхлээд албан бус боловсролын гэр сургууль, цэцэрлэгийг уурхайн ойролцоо байгуулж ажиллуулсан. Тэнд ажиллаж байгаа насанд хүрэгчдийн хүүхдийн хөдөлмөрийн талаарх ойлголтыг өөрчилж, тэдний дэмжлэгийг авах шаардлагатай байлаа. Алтны газарт аливаа үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй байдаг тул юуны түрүүнд тэнд олон жил алт ухан амьдарч байгаа болон дэлгүүр, гуанз ажиллуулдаг нийгмийн идэвх сайтай зарим иргэдийн оролцоотойгоор төрөл бүрийн үйл ажиллагааг зохион байгуулах хэрэгтэй болсон. Ингээд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүллээ:

- Эхлээд “Алтан ус”-д үйл ажиллагаа явуулж байгаа 20 гаруй иргэн, Баянхонгор аймаг болон Баян-Овоо сумын багийн Засаг дарга, нийгмийн ажилтнуудыг оролцуулан “ХХТХ-ийг устгахад олон нийтийн хүчийг дайчлах нь” хэлэлцүүлгийг зохион байгуулав. Алт олборлогчид болон үйлчилгээ эрхэлдэг хүмүүс өөрсдөө олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, хүүхдийг уурхайн хөдөлмөрөөс хөндийрүүлэх үйл ажиллагаанд хэрхэн оролцохоо тодорхойлон гаргасан. Тэд өөрсдийн хүрээний 30-40 хүнд нөлөөлөх ажлыг үргэлж хийгээд байж чадна гэж санаачилсанг дэмжиж, алтны нүх рүү хүүхдийг оруулахгүй байх, олон нийтэд алтны нүх рүү хүүхэд орж ажиллах нь аюултай болох талаар ухуулга явуулдаг боллоо. Үүний үр дүнд хүүхэд нүхэнд орж ажиллахаа больсон.
- Эдгээр идэвхтнүүд “Алтан ус”-д ажиллаж байгаа гэр сургуулийн багштай хамтран ажиллах гэрээ байгуулж, 7 хоногт нэг удаа олон нийтийн ойлголт дээшлүүлэх үйл ажиллагааг олон хэлбэрээр явууллаа. Тэдний оролцоотойгоор “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгахад бидний оролцоо” сэдэвт дэвжээ тэмцээнийг зохион байгуулахад гар аргаар алт олборлогчид жүжигчилсэн тоглолтоороо өөрсдийнх нь ажиллаж, амьдарч буй газарт бий болсон тулгамдсан асуудлуудыг чадварлаг гаргаж тавьж байв.
- Энэ дэвжээ тэмцээнийг Баянхонгор аймгийн телевизээр үзүүлж, шийдвэр

гаргагчид болон олон нийтэд хүргэсэн.

- Алтны газар байгуулсан албан бус сургалтын гэр сургуулийг алтны газарт байгаа гэрэл гэгээтэй ганц газар гэж алт олборлогчид үзэж байлаа. Идэвхтнүүдийнхээ оролцоотойгоор хурал цуглаан, эрүүл мэндийн үзлэг, мэдээлэл, хэлэлцүүлэг, тэмцээн уралдааныг олон удаа зохион байгуулсан нь алт олборлогч иргэдийн оролцоог идэвхжүүлэхэд нөлөөлж байлаа. Мөн сайн дурын идэвхтнүүдийн оролцоотойгоор хөрсний нөхөн сэргээлтийг тодорхой газар хийж, тухайн газар дээр нь гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулсан нь хүмүүс хийсэн ажлаараа бахархах, газар дэлхийгээ хайрлах өөдрөг сэтгэлзүйг бий болгож байсан.
- Сайн дурын идэвхтнүүдтэй байгуулсан гэрээний биелэлтийг тодорхой хугацааны дараа дүгнэсэн. Тэдний оролцоотойгоор уурхайн хөдөлмөрөөс хөндийрсөн хүүхдүүдийн нөхцөл байдалд мониторинг хийж, шинээр хүүхэд нэмэгдэхээс урьдчилан сэргийлж чадлаа.
- Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг Дэлхийн өдрийг угтан Баянхонгор сумын багуудын хооронд зохион байгуулсан дэвжээ тэмцээний удирдамжид алтны газарт байрлуулах мэдээллийн самбар хийх даалгаврыг өгснөөр олон нийтийн ойлголт дээшлүүлэх сурталчилгааны олон сайхан самбартэй болсон. Эдгээр самбарыг алтны газруудад байрлуулж, сайн дурын идэвхтэн гишүүдийнхээ оролцоотойгоор харж, хамгаалж байна.

Үр дүн:

- Алтны газар сургалт явуулдаг гэрийг олон нийтийн ойлголт хандлагыг дээшлүүлэхэд байнга ашигладаг болсон.
- Алтны уурхайд ажиллаж байгаа хүмүүс хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог болсон.
- Алтны газар байгуулсан гэр сургуульд хамрагдсан хүүхэд хөдөлмөрөөс хөндийрөөд эргээд ажиллаж эхэлбэл эцэг эхтэй уулзах, тэдэнд шаардлага тавих, бидэнд мэдээлэл хүргэх зэрэг ажлыг сайн дурын идэвхтнүүд хийдэг. Хүүхдийн хөдөлмөрийн байнгын хяналт бий болсон.
- Сайн дурын идэвхтнүүдийн оролцоотойгоор гар аргаар алт олборлогчдын дунд уралдаан, тэмцээн зохиох, мэдээлэл хүргэх болон эрүүл мэндийн үзлэгт хамруулах зэрэг төрөл бүрийн ажлыг хийхэд хүмүүсийг оролцуулах, цуглуулах ажлыг түвэггүй хийх бололцоотой болсон.

Сайн туршлагыг хэрэгжүүлэх нөхцөл:

- Гар аргаар алт олборлогчдод хандсан төрөл бүрийн арга хэмжээг тэдний оролцоонд түшиглэн зохион байгуулахаар төлөвлөх
- Алтны уурхай дээр ажилладаг дэлгүүрийн эрхлэгч, гуанзны эзэн, алт авдаг хүмүүс болон тэнд олон жил амьдарч байгаа хүмүүсийн судалгааг гаргаж, сургалт явуулан, тэдэнд итгэл хүлээлгэх.

Сайн туршлагаас гарсан сургамж:

- Төрийн зүгээс үйлчилгээ үзүүлдэг гэр сургууль, цэцэрлэг гэх мэт үйлчилгээний цэгийг байгуулж, идэвхтнүүдийн үйл ажиллагааг уялдуулсан нь илүү үр дүнтэй байсан.

- Алтны уурхайд олон жил ажилласан, олонд танигдсан хүмүүст хүлээн зөвшөөрөгдсөн хүмүүсийг сайн дурын идэвхтнээр сонгон ажиллуулахын тулд тэдэнд итгэл өгч, нэг бүрчлэн уулзаж, хийх ажлынх нь ач холбогдолыг ойлгуулах нь чухал.
- Гар аргаар алт олборлож байгаа хүмүүсийн дунд тэдний оролцоонд тулгуурласан соёл, олон нийтийн үйл ажиллагааг тодорхой хугацаанд зохион байгуулж байх нь тэднийг зохион байгуултад оруулахад үр нөлөөтэй.
- Олон нийтийн оролцоог дайчлахын тулд тухайн газраас сонгогдсон Иргэдийн Хурлын төлөөлөгч, аймаг, сумын Засаг даргын Тамгын газрын удирдах албан тушаалтнууд очиж, тэдгээр хүмүүстэй хэлэлцүүлэг зохион байгуулж, явцын дунд ч уулзаж санал солилцоход хүмүүсийн сэтгэхүйд чухал нөлөө үзүүлж байсан.

Сайн туршлагын талаар нэмэлт мэдээлэл өгөх хүмүүс:

- Ж. Дуламсүрэн, Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтсийн хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, утас: 99448239, 93075890, э-шуудан j_duya@yahoo.com
- Д. Адъяа, Баян-Овоо сумын Албан бус боловсролын арга зүйч, утас 91449699.

Хавсралт 11. Хүүхдийн хөдөлмөрийн талаар худалдааны захын олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх нь

Байгууллагын нэр: Тэгш Мөр Төв ТББ

Үндэслэл. Улаанбаатар хотод албан бус хэвшилд хөдөлмөр эрхэлдэг хүүхдийн дийлэнх нь худалдааны зах дээр ажилладаг. АЙПЕК хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Нийслэлийн худалдааны зургаан том зах (Цайз, Хүчит шонхор, Хархорин, Да хүрээ, Хангай, Барс зах)-ын олон нийтэд хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийн тухай ойлголтыг нэмэгдүүлж, хүүхдийн хөдөлмөрийг устгах орчныг бий болгох зорилгоор ажиллаж эхэлсэн юм. Үүний тулд эдгээр зах дээр хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдээс гадна захын удирдлага болон ажиллагсад, түрээслэгч нартай хамтран ажиллах шаардлагатай байв.

Сайн туршлагыг хэрэгжүүлсэн үйл явц. Захын олон нийт гэдэгт захын удирдлага, менежер, байцаагч, түрээслэгч нарыг багтааж, тэдний ойлголтыг дээшлүүлэхэд дараахь багц үйл ажиллагааг чиглүүлсэн юм. Үүнд:

- Худалдааны захын захиргаа, түрээслэгчтэй хийдэг гэрээнд хүүхдээр аюултай, хүнд хөдөлмөр хийлгүүлэхгүй байх, хүүхдийн эрхийг хүндэтгэх, насанд хүрээгүй хүний өргөх, зөөх ачааны зөвшөөрөгдөх дээд хэмжээг баримтлан ажиллуулах, хүүхдийн эрхийг ноцтой зөрчсөн тохиолдолд холбогдох байгууллагад мэдээлж байх тухай заалт оруулж өгсөн. Худалдааны зах тус бүр өөр өөрийн онцлогтой учраас тухайн онцлогт тохирсон заалтуудыг захын удирдлагуудтай хамтран боловсруулж тусгаж өгсөн.
- Үйлчлүүлэгч, түрээслэгч нарт захын хаалган дээр тараадаг санамжинд хүүхдийн эрхийг таниулсан мэдээлэл тусгаж оруулсан.
- “Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг бидний хамтын ажиллагаа” сургалтыг захын удирдлага, ажиллагсдын дунд зохион байгуулсан. Түүнчлэн захын ойролцоо оршдог хороо, сургуулийн нийгмийн ажилтнуудад хүүхдийн хөдөлмөрийн холбогдолтой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар сургалтууд зохион байгуулж байв.
- Насанд хүрээгүй хүний өргөх, зөөх ачааны хүнд зөвшөөрөгдөх дээд хэмжээний стандартыг харуулсан самбарыг зах бүр дээр байрлуулж, эдгээр нь захын олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэхэд хэр нөлөөлсөн талаар үнэлгээ хийж, сурталчилгааны ажлын төлөвлөгөөгөө хянан үзэж байв.
- Тухайн зах бүр дээр оршиж буй хүүхдэд хамгийн аюултай, хортой газруудыг захын ажиллагсдаар болон хүүхдүүдээр хэлэлцүүлэн тодорхойлж, хөрөө рам, нүүрс ачсан ачааны машин дамжин өнгөрдөг хаалга гэх мэт тодорхой байршлыг “Хүүхдийн хөдөлмөргүй орчин” болгох зорилтын төлөө төслийн баг, захын удирдлага, ажиллагсад болон хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд хамтран ажилласан.
- Зах дээр “Хүүхдийн хөдөлмөр” гар зургийн уралдаан зохион байгуулж, олон нийтийг татан оролцуулсан.
- Худалдааны захууд дээр хүүхдийн хөдөлмөрийн мониторинг хийх талаар захын удирдлага, ажиллагсадтай харилцан тохиролцож, сургалт хэлэлцүүлэг хийж, улмаар хэрэгжүүлэх арга замаа тодорхойлсон. Зах тус бүр дээр хүүхдийн хөдөлмөр хариуцсан ажилтан ажиллаж байгаа ба зарим нэг зах дээр мониторингийн баг байгуулан ажиллаж байна.
- Тодорхой зорилготой “бичил” төслийг захын удирдлагатай хамтран хэрэгжүүлсэн.

Жишээ нь, “Хангай” зах дээр явж байгаа машин дээрээс нүүрс шүүрдэг хүүхдүүдийн судалгааг гаргаж, голдуу нүүрс, түлээ жижиглэнгээр зардаг эцэг эхчүүдийг захын түрээсийн төлбөрөөс зургаан сарын хугацаагаар чөлөөлж, тэдний зарж борлуулж буй түлээ, нүүрсний хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн мөнгөн дэмжлэгийг үзүүлж, оронд нь хүүхдийг албан бус сургалтад хамруулах, улмаар дүүргийн Гэгээрэл хөгжлийн төвд шилжүүлж, хөдөлмөрөөс хөндийрүүлэх “Болжмор” нэртэй жижиг төслийг амжилттай хэрэгжүүлсэн.

Ойлголт нэмэгдүүлэх үйл ажиллагааны бэлтгэл үе шатанд эдгээр зах дээр хөдөлмөр эрхэлдэг хүүхдийн судалгааг гаргаж, зах бүрийн удирдлагатай уулзаж, хэрэгжүүлэх ажлынхаа зорилго, стратеги, хэрхэн хамтран ажиллах талаар санал солилцон, үйл ажиллагааны хамтарсан төлөвлөгөө боловсруулж ажилласан юм.

Үр дүн:

- Худалдааны зах дээр хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийн эсрэг хандлага бий болж, хүүхдийн эрхийг хамгаалах орчин бүрдсэн.
- Худалдааны таван зах дээр хүүхэд ажиллахад аюултай, хортой байршлуудыг “Хүүхдийн хөдөлмөргүй орчин” болгож, хаягжуулсан. Хүүхдийн хөдөлмөргүй орчноор тодорхойлсон газарт нэг ч хүүхэд ажиллахгүй байгаа. Үүнд тухайн захыг хариуцсан байцаагч, цагдаа нар хяналт тавьдаг болсон.
- Худалдааны захын зүгээс хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдэд анхаарал тавьж эхэлсэн. Жишээ нь, Да хүрээ захад хүүхдийн хөдөлмөрийн мониторингийн баг ажиллаж байна. Хүчит шонхор захын удирдлага, албан хаагчид дотоод менежментээ сайжруулснаар хүүхэд ажиллахгүй байх орчин бүрдүүлэн ажиллаж байна. Хангай, Барс, Хархорин, Цайз зах манай байгууллагатай байнгын хамтын ажиллагаатай ажиллаж байна.
- Хүүхдүүдийн суралцах сонирхол нэмэгдсэн. Хүүхдийн зан төлөвт эерэг өөрчлөлтүүд гарсан. Эцэг эх, хүүхдийн хүүхдийн хөдөлмөрийн хор уршгийн тухай ойлголт нэмэгдэж, аюултай хөдөлмөрөөс зайлсхийх хандлага бий болж байна.

Сайн туршлагыг хэрэгжүүлэх нөхцөл:

- Захын удирдлагуудын хүүхдийн хөдөлмөрийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, байнгын хамтын ажиллагаатай ажиллах,

Сайн туршлагаас гарсан сургамж:

- Хүүхдийн эрх, хүүхдийн хөдөлмөрийн асуудлаарх мэдээлэл, гарын авлага материалаар хангах, зохион байгуулж буй аливаа үйл ажиллагаанд удирдах албан тушаалтнуудыг байнга татан оролцуулах нь чухал.
- Захын удирдлага, түрээслэгч нарын хоорондын гэрээний хэрэгжилтэд байнга хянах мониторинг хийх шаардлагатай. Захын удирдлага, түрээслэгч нарын хоорондын гэрээг биелүүлээгүй тохиолдолд хүлээх хариуцлагыг хуулийн хүрээнд нарийн тодорхойлох шаардлагатай нь харагдсан.
- Зах дээрх үйл ажиллагааны зэрэгцээ хороо, дүүрэгтэй хамтран ажиллах нь чухал болох нь мэдрэгдсэн.
- Хүүхдийн хөдөлмөртэй холбоотой хууль, журмыг сурталчлахаас хор холбогдлыг

таниулах нь илүү ач холбогдолтой нь ажиглагдсан.

- Хөдөлмөр эрхэлдэг, тэр дундаа гэмт хэрэгт өртөх эрсдэлтэй хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг захын удирдлага, хуулийн байгууллага дэмжин ажиллах сонирхолтой байсан.

Сайн туршлагын талаар нэмэлт мэдээлэл өгөх хүн:

- П. Алгирмаа, утас 88006346, algirmaa@cyppd.org

Хавсралт 12. Хүүхдийн хөдөлмөрийн мониторинг

Байгууллагын нэр: Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар

Үндэслэл: 1990-ээд оны эхээр Налайхын уурхай хаагдсанаас хойш Налайх дүүргийн оршин суугчдын дунд ажилгүйдэл ихэсч, улмаар амьжиргааны түвшин буурч, хүүхдүүд орлого олохын тулд хаагдсан уурхай орчимд ажил хийх нь ихэссэн билээ. 2000 он гарсаар шилжилт хөдөлгөөн улам эрчимжиж, хөдөө орон нутгаас Налайх дүүрэгт түр хугацаагаар болон байнга оршин суухаар шилжин ирэгсэд олширсоор байгаа юм. Нийгэм, эдийн засгийн энэ өөрчлөлтийг дагаад хүүхдүүд Налайхын хаагдсан уурхайд болон уурхай орчим, түүнчлэн сүүлийн үед олноор нээгдэх болсон тоосгоны үйлдвэрт ажиллах болсон.

2006 оноос Дүүргийн Засаг даргын захирамжаар хүүхдийн хөдөлмөрийн мониторингийн багийг байгуулж ажилласан юм. Энэхүү мониторингийн баг уурхай, тоосгоны үйлдвэр, үйлчилгээний газарт хүүхдийн хөдөлмөрийг илрүүлэх, таслан зогсоох, улмаар хүүхдийг сургуульд нь буцаан оруулах, гэр бүлийн гишүүд, хүүхдэд хуулийн хүрээнд нийгмийн халамжийн үйлчилгээ хүргэх зорилготой байлаа. Ийнхүү ажиллах явцад ажлын байрт чиглэсэн мониторингоос гадна сургууль, хорооны түвшинд мониторинг хийж, холбогдох мэргэжилтнүүдийн хамтын ажиллагаа, гэр бүлд үзүүлэх туслалцааг уялдуулж байж хүүхдийг аюултай хөдөлмөрөөс хөндийрүүлэх ажил илүү үр дүнд хүрнэ гэдгийг мэдэрсэн юм.

Сайн туршлагыг хэрэгжүүлсэн үйл явц: Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах Налайх дүүргийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд анхан шатны нэгжийн оролцоог нэмэгдүүлэх үүднээс хороо бүрт (5 хороонд) хүүхдийн хөдөлмөрийн мониторингийн сайн дурын идэвхтнүүдийг сонгож ажиллуулж эхлэв. Дүүргийн нийгмийн хөгжлийн хэлтсээс сайн дурын идэвхтнүүдэд ажлын чиглэл өгч, ойлголт нэмэгдүүлэх сургалтад хамруулан дэмжиж байлаа. Гэвч мониторингийн явцад сайн дурын ажилтан ганцаараа үр дүнтэй мониторинг хийхэд хангалтгүй байгаа нь ажиглагдсан. Тиймээс, хороодын нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхэлдэг, эрхлэх эрсдэлтэй хүүхдийг хөндийрүүлэх, урьдчилан сэргийлэх мониторингийн багийг 5-6 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан юм. Түүнчлэн, 2009 оноос эхлэн сургуулиудад мониторингийн багийг сургалтын менежер, багш (3-4), нийгмийн ажилтан, эцэг эхийн зөвлөлийн гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллаж байна.

Хороо, сургууль дээрх мониторингийн багийг тус хорооны Засаг даргын захирамж, сургуулийн захирлын тушаалаар байгуулагдсан. Дүүргийн Нийгмийн хэлтсээс мониторингийн багуудын ажлын чиглэлийг гаргаж өгөв. Дүүрэг, хороо, сургуулийн мониторингийн багууд хоорондоо харилцан мэдээлэл солилцох замаар холбогдож ажиллах шаардлагатайг онцолдог. Хорооны халамжийн ажилтан мониторингийн багт багтдаг бөгөөд амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүн учраас шаардлагатай өрхийн амьжиргааг дэмжих саналаа (эцэг эхийг нь ажил зуучлах, сургалтад хамруулах) Дүүргийн холбогдох хэлтэст уламжилдаг.

Мониторингийн багууд ажлынхаа явцад дараахь баримт бичгийг хөтөлж, ашиглаж хэвшлээ. Үүнд:

- Бүртгэлийн маягт (хүүхэд илэрсэн даруйд хүүхдийн талаар шуурхай мэдээлэл авах хуудас)

- Үйлчилгээний тэмдэглэл (тухайн хүүхэд ямар үйлчилгээнд хамрагдсан, ямар үр дүнд хүрснийг тэмдэглэх дэвтэр)

Мониторингийн багуудын ажлын үр дүнг Нийгмийн хэлтсийн дарга, сургуулийн захиралтай хийсэн мониторингийн багийн гишүүдийн үр дүнгийн гэрээний биелэлтээр хянаж байна. Ажлын үр дүнг бодитой үнэлэхийн тулд *Хөдөлмөр эрхэлдэг эсвэл эрхлэх эрсдэлтэй хүүхдийн үйлчилгээний бүртгэлийг* ашиглааар төлөвлөж байна. Түүнчлэн, үр дүнгийн гэрээг дүгнэхдээ тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд хөдөлмөр эрхэлдэг хүүхдийн тоо хэрхэн өөрчлөгдөж байгааг харьцуулан судалж хэлэлцдэг.

Үр дүн:

- Энэ хугацаанд төрийн албан хаагчид багаар ажиллах чадварт суралцаж, сургалт сурталчилгаа хийх, хөдөлмөр эрхэлдэг хүүхдийг хөдөлмөрөөс нь хөндийрүүлэх аргачлалд чадавхижлаа.
- Хүүхдийн хөдөлмөрийн мониторингийн ажлын хэсгүүд тогтвортой ажиллах болсон. Налайх дүүрэгт хүүхэд аюултай ажил эрхлэх нь тогтвортой буурч байна. Нүүрсний уурхайд, газар дор ажилладаг хүүхэд байхгүй болсон.

Сайн туршлагыг хэрэгжүүлэх нөхцөл:

- Бүх түвшинд ойлголт нэгдсэн байх, нэн тэргүүнд анхаарал хандуулах асуудлаа тодорхойлох
- Үр дүнг тооцох шалгуур үзүүлэлтүүд, мониторингийн багийг гишүүдийн ажил, үүргийн хуваарийг тодорхой болгох
- Мониторингийн багуудыг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр (жишээ нь сургуульд сургуулийн захирал, хороонд хорооны ЗД) байгуулж, дүүргийн Нийгмийн хэлтэс удирдлага арга зүйгээр хангадаг, ажлын чиг үүргийг гаргадаг байх

Сайн туршлагаас гарсан сургамж:

- Орон нутгийн онцлогоос шалтгаалан, хорооны түвшинд ажиллах мониторингийн багийн гишүүд өөр өөр байж болно. Гэвч ажил үүргийн дагуу хүүхдэд анхаарал тавих ёстой албан хаагч бүр багтсан байвал сайн. Жишээ нь, нийгмийн ажилтан, өрхийн эмч, хэсгийн ахлагч, сайн дурын идэвхтэн г.м.
- Хүүхдийн хөдөлмөрийн хор уршгийн тухай олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх нь ажлын үр дүнг тогтвортой болгоно.
- Шинээр улирлын чанартай болон байнга оршин суухаар шилжин ирэгсдэд онцгой анхаарал хандуулж сурталчилгаа, ухуулга хийх хэрэгтэй.
- Мониторингийн багийн гишүүд солигдсон ч тухайн нэгжийн албан хаагчид хүүхдийн хөдөлмөрийн талаар ойлголт өгөх, дотооддоо сургалт зохион байгуулах чадвартай байвал ажлын үр дүнд эерэгээр нөлөөлнө.
- Мониторингийн багт сайн дурын идэвхтнийг өргөнөөр оролцуулах хэрэгтэй. Ингэхдээ тухайн хамрах хүрээнд оршин суудаг, орчин нөхцөл, хөрш оршин суугчдаа сайн таньдаг нөлөө бүхийн хүн байвал оновчтой.

Сайн туршлагын талаар нэмэлт мэдээлэл өгөх хүмүүс:

- Д.Эрдэнэцэцэг, Налайх дүүргийн ЗДТГ-ын Нийгмийн хэлтсийн дарга, утас: 99288596, э-шуудан: erdenetsetseg_nd@yahoo.com
- Д.Тунгалаг, дүүргийн Нийгмийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, утас: 88195171, э-шуудан: tungalag9999@yahoo.com

Налайх дүүргийн мониторингийн багуудын ажиллах зарчим

Дүүргийн Нийгмийн хэлтэс
(багуудын үйл ажиллагааны уялдаа, нийгмийн үйлчилгээний
төлөвлөлт, ажлын үр дүнгийн хяналт)

Ажлын байрт чиглэсэн мониторинг

Дүүргийн мониторингийн ажлын хэсэг
(Налайх дүүргийн засаг даргын
захирамж)

Насанд хүрээгүй хүүхдийг шөнийн
цагаар ажиллуулах, хүнд буюу тэвчишгүй
хөдөлмөр эрхлэхийг таслан зогсоох
зорилготой.

Ажлын хэсгийн дарга: Нийгмийн хэлтсийн
дарга

Гишүүд:

- Хөдөлмөр, нийгмийн халамж
хамгаалал хариуцсан мэргэжилтэн
- Хүнс, хөдөө аж ахуй, нийтийн хоолны
үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
- Жижиг, дунд үйлдвэрлэл хариуцсан
мэргэжилтэн
- Мэргэжлийн хяналтын хэлтсийн
хүүхэд, өсвөр үеийн эрүүл ахуйн
хяналтын улсын байцаагч
- Цагдаагийн хэлтсийн хүүхдийн
байцаагч
- Хорооны нийгмийн ажилтнууд
- Сургуулийн нийгмийн ажилтнууд

Оршин суугаа газарт суурилсан мониторинг

Хорооны мониторингийн баг
(Хорооны 3Д-ын захирамж)

Багийн ахлагч: Хорооны нийгмийн ажилтан
Гишүүд:

- Хорооны зохион байгуулагч
- Хэсгийн дарга нар
- Олон нийтийн байцаагч
- Өрхийн эмч

Үйл ажиллагаа:

- Хүүхэд тэвчишгүй хүнд хөдөлмөр эрхэлснээр
ямар хор холбогдолтой болох талаар Хорооны
иргэдэд сурталчлах
- Хөдөлмөр эрхэлдэг хүүхдийн мэдээллийг
нэгтгэх, тайлагнах
- Мониторингийн үр дүнд илэрсэн хүүхдүүдийг
боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд
хамруулах
- Хүүхдийн хөдөлмөрийн талаар гарсан хууль
дүрмийг тухайн хороонд үйл ажиллагаа
явуулдаг байгууллага аж ахуйн нэгжид таниулах
- Хүүхдүүд аюултай ажил эрхлэхээс урьдчилан
сэргийлэх

Зорилтот бүлэг:

- хөдөлмөр эрхэлж байгаа хүүхэд
- хөдөлмөр эрхлэх эрсдэлтэй хүүхэд
- сургууль завсардсан хүүхэд
- хүнд нөхцөлд байгаа хүүхэд
- хүүхдүүдийн эцэг эх, гэр бүл

Сургууль дээрх мониторинг

Сургуулийн мониторингийн баг
(Сургуулийн захирлын тушаал)

Багийн ахлагч: Сургалтын менежер

Гишүүд:

- Нийгмийн ажилтан
- Багш нар (3-4)
- Эцэг эхийн зөвлөлийн төлөөлөл

Үйл ажиллагаа:

- Хичээлээс гадуур хөдөлмөр эрхлэх эрсдэлтэй
хүүхдийн судалгааг анги бүрээр гаргах
- Хүүхдүүдэд тусалцаа үзүүлэх, хичээлийн
хэрэглэл, ном сурах бичиг, дүрэмт хувцсаар
хангах
- Хүүхдийн хөдөлмөр, түүний хор холбогдлын
талаар сургалт сурталчилгаа хийх
- Хөдөлмөр эрхэлж байгаад ЕБС руу шилжин
ирэх сурагчидтай нэг бүрчлэн ажиллах, эдгээр
хүүхдийг дүүрэг, сургуулийн хэмжээнд зохион
байгуулдаг спорт, урлаг, соёлын арга хэмжээнд
түлхүү оролцуулах
- Сургуулийнхаа сурагчдыг боловсролоос
хөндийрүүлэхгүй байхад үйл ажиллагаагаа
чиглүүлэх

Зорилтот бүлэг:

- Өнчин болон хүнд нөхцөлд байгаа хүүхэд
- Сургууль завсардаж болзошгүй хүүхэд
- Завсардаад ЕБС-руу эргэн орсон хүүхэд

